**БАТЛАВ**
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН ДАРГА

................................. /                         /

**БАТЛАВ**
ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН
“ЯАРМАГ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

................................. /Б.НЯМЦЭРЭН/

Yarmag

# ЯАРМАГ ХХК-НЫ “АРЬС ШИР БОЛОВСРУУЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

РЕГИСТРИЙН ДУГААР: **2595117**

ХЯНАСАН:
БОУАӨЯ-НЫ ХБОБХГ-ЫН
МЭРГЭЖИЛТЭН________________________________/                         /

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:
ЯАРМАГ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ ________________________________/ Б.НЯМЦЭРЭН /

**2024**

1. **Тухайн жилийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн товч танилцуулга**
2. **Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт**
3. **Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт**
4. **Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт**
5. **Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт**
6. **Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт**
7. **Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт**
8. **Дүгнэлт**
9. **Тайлангийн хавсралтууд**

## 1. ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төслийн байршил:** Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг 20-р хорооны нутаг дэвсгэрт хуучнаар АШҮН-ийн хашаанд
**Төсөл хэрэгжүүлэгч:** Яармаг ХХК, регистрийн дугаар 2595217, улсын бүртгэлийн дугаар 9011470088
**Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:** Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, АШҮН-н хашаанд, Үйлдвэр -17042/44. Утас: 99134550, 99040007

### 1.1. Түүхэн товчоо

“ЯАРМАГ” ХХК нь 1992 онд Монгол орны малын гаралтай түүхий болох арьс, шир бэлтгэх, боловсруулах, экспортонд гаргах чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зорилгоор байгуулагдсан бөгөөд өнөөдрийг хүртэл бизнесийн үйл ажиллагаагаа өргөтгөн, 32 жил тогтвортой эрхэлж байгаа зах зээлийн нийгмийн анхны үйлдвэрүүдийн нэг билээ.

“ЯАРМАГ” ХХК нь анх 1992 онд Яармаг Хоршоо хэлбэрээр БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Х.Бямбажав өөрийн санаачлага, хөрөнгөөр үүсгэн байгуулагдаж тарвага ангийн арьс боловсруулан тарваган шуба хийн ОХУ-д экспортлон үйл ажиллагаагаа эхэлсэн юм.

1993-2000 онд жилд 2-50 мянган ширхэг тарвага, каракуль, булганы арьс боловсруулж 50-1200 үслэг эдлэл хувцас, 1997 оноос бодын арьс боловсруулж гутлын булигаар үйлдвэрлэж, улмаар үйлдвэрлэлээ өргөгтгөн арьс шир боловсруулах тоног төхөөрөмжөө шинэчлэн хүчин чадлыг нэмэгдүүлснээр 2000 оноос “Яармаг” хоршоог “Яармаг” ХХК болгон өөрчлөн байгуулсан. Үйлдвэрлэлийн барилгыг өргөгтгөн барьж, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлснээр жилд боловсруулах арьс ширний тоо хэмжээ нэмэгдэж хоногт 4500 богын арьс, 1000 бодын арьс боловсруулах хүчин чадалтай болсноор жилийн орлого, ажлын байрны тоо нэмэгдсэн. 2014 оноос гадаад зах зээлээ тэлж хагас боловсруулсан хонь, ямаа, үхрийн арьсыг Европын зах зээлд Итали, Турк улс руу экспортолж эхэлсэн билээ. Хоногт 5000 богийн арьс, 800 бодийн шир, 100 мян.дм2 краст боловсруулах хүчин чадалтай. Үйлдвэр өдрийн 8 цагаар, технологийн шаардлагаар зарим дамжлага илүү цагаар ажилладаг ба нэг ээлжтэй. Үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд БНХАУ, Чех, Итали улсад үйлдвэрлэгдсэн.

### 1.2 Бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Арьс шир боловсруулах үйлдвэрлэл нь улирлын шинж чанартай үйлдвэрлэлд багтдаг. 2024 онд 3-5-р саруудад нойтон цехэд нэмэлт идээлгэ, будах, хуурай цехэд арьсыг гүйцээн боловсруулах механик үйл ажиллагаа явагдсан ба захиалгаар цөөн тооны ямааны арьс зумлах ажлыг хийж гүйцэтгэсэн.

2023 онд Итали улсад үхрийн нойтон хөх шир экспортлохоор хийгдсэн гэрээ Орос-Украйны дайн, тээвэр ложистикийн асуудлаас болон цуцлагдсан болно. Шинээр түүхий эд арьс шир худалдаж аваагүй, 6-р сараас 10-р саруудад сул зогсолттой байлаа. 2024 оны 11 сараас зөвхөн хуурай буюу механик цех цөөхөн орон тоогоор дотоодын зах зээлд 2025 оны 1-р сард борлуулагдах хромон гутлын арьсыг гүйцээн боловсруулах ажил хийгдэж эхлээд байна.

2024 оны хувьд Европын зах зээлд манай бүтээгдэхүүний эрэлт огцом буурч экспорт зогссон. Олон улсын нөхцөл байдал, тээвэр логистикийн хүндрэлээс шалтгаалан үйл ажиллагаа зогсонги байдалд хэвээр үргэлжлэв.

2024 онд нийт 157000 ямааны арьс зумласан, 8000 ширхэг бодын шир боловсруулан гутлын дээд биений арьс, дотуур ул, улны шир, богын арьсаар гутлын дотор зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ.

## 1.3 Тусгай зөвшөөрөл, бусад бичиг баримтууд

БОАЖЯ-ны 2021 оны 7-р сарын 30 өдрийн 13/3347 тоотоор ерөнхий дүгнэлт гарсан ба Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан нэмэлт тодотгол 2022 онд батлагдсан.

ХХАБодис импортлох, ашиглах тусгай зөвшөөрөл - №0002103, 2022/03/01 3жил

Ус ашиглуулах дүгнэлт - №2024/25, 2024/04/04

Ус ашиглах эрхийн бичиг - №24/2015, Сунгалт – 2022/05/30: 3 жил

## 1.4 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслийн хүрээнд байгалийн нөөцийг ашиглах үйл ажиллагаа явуулдаггүй. Төслийн байгаль орчинд нөлөөлөх болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг БОНҮТ-нд арьс шир боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас агаар орчин, хөрсөн бүрхэвчид нөлөөлөх болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагавар нь дунд үнэлгээгээр ба экологийн бусад хэсгүүдэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй гэж дүгнэгдсэн.

Хүснэгт-1: БОННҮ -ээр тогтоосон төслийн гол ба болзошгүй нөлөөлөл

| **Байгаль орчин** | **Нөлөөллийн эрчим, цар хүрээ** | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Маш бага, нөлөөгүй | Бага | Дунд | Их | Онц аюултай | Нөлөөллийн зэрэг | Хувиар |
| Газрын гадарга, хэвлий | | | | | | Нөлөөгүй | |
| Хөрсөнд нөлөөлөх байдал | 1 | 2 | | | | Бага | 18.75% |
| Агаарын чанарт нөлөөлөх байдал | | | 2 | 1 | | Дунд | 18.75% |
| Гадаргын болон газрын доорх ус | | 1 | 3 | | | Дунд | 25% |
| Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдал | 1 | 2 | | | | Бага | 18.75% |
| Амьтны аймаг | | | | | | Нөлөөгүй | |
| Түүх соёлын өв | | | | | | Нөлөөгүй | |
| Ажиллагсадын эрүүл мэндэд нөлөөлөх байдал | | | 3 | | | Дунд | 18.75% |
| Нийт | 2 | 5 | 8 | 1 | | | |
| Хувиар | 12,5% | 31,25% | 50% | 6,25% | | | |
| **Дүгнэлт** | Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг “ДУНД” гэж үзэхээр байна. | | | | | | |

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Хүснэгт 2.1. Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэрэгжилт | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Бохир усны шугам хоолойн битүүмжлэл алдагдсанаас нэвчиж байгальд асгаран орчны агаарыг бохирдуулах; | Үйлдвэрийн бохир усны шугам хоолойг тогтмол цэвэрлэх, хатуу болон шингэн хаягдлаар агаар бохирдохоос сэргийлэх арга хэмжээ авах; | Үйлдвэрийн бохирын шугам хоолой | Тогтмол хэрэгжүүлж байна | Үйлдвэрийн доторх бохир усны трап шугамууд стандартын дагуу хийгдсэн ба лаг хамагчтай хөдөлгөөнтэй, хөдөлгөөнгүй шүүрүүдийн нэвтрэх чадварыг нарийсгасан, бохир усны гаргалгаан дээр лагыг цэвэрлэж авч байх тогтмол ажилчинг ажиллуулдаг. |
| 2 | Арьсны тосыг дутуу авснаас болон хаягдал бохир ус хүчилтөрөгчтэй исэлдсэний улмаас хийн төлөвт шилжсэн хэсэг нь агаарт тархаж үнэр гарах | Арьсны тосыг гүйцэд авах, ургамлын ба цагаан идээлэгтэй технологийг нэвтрүүлэх зэргээр технологи байнга ашиглах | Нойтон боловсруу-лалтын үйлдвэрт | Тогтмол хэрэгжүүлж байна | Арьсны тос авах болон ургамлын идээлгийн бодисыг Испанийн арьс ширний үйлдвэрийн химийн материалын үйлдвэрлэгч Quimser компанийн бүтээгдэхүүнийг хэрэглэж байна тус компани нь ОУ-ын стандарт ZDHC - Химийн аюултай бодисыг тэг ялгаруулах буюу нэхмэл эдлэл, гутлын үйлдвэрт химийн хорт бодисын хэрэглээг арилгах зорилготой дэлхийн хамтын санаачилга бөгөөд үүний 2 ба 3-р түвшинд хүргэсэнг батлах салбарынхаа шилдэг гэрчилгээг эзэмшигч мөн Европын REACH журамд нийцүүлэн бүтээгдэхүүнээ үйлдвэрлэдэг, REACH нь Европын холбооны химийн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ химийн бүтээгдэхүүнээс гарч болзошгүй эрсдэлээс хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг сайжруулах зорилгоор батлагдсан Европын холбооны журам юм.<br><br>https://quimser.com/certificates/ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | Арьс шир боловсруулах үйлдвэрт хэрэглэгдэж байгаа химийн бодисын уургшилтаас | Химийн бодис асгарч уургшихаас бүрэн хамгаалах, орц, норм хэмжээг хэтрүүлэхээс сэргийлж байнгын хяналт тавьж ажиллах; | Нойтон боловсруу-лалтын үйлдвэрт | Тогтмол хэрэгжүүлж байна | Химийн бодис материалын агуулахын стандартыг мөрдөж ажилладаг ба нэг удаагийн химийн бодисын худалдан авалтын хэмжээг аль болох бага байхаар тооцон бараа материалын татан авалтыг хийж хэвшсэн болно. |
| 4 | Ажлын байрны температур, гэрэлтүүлэг, чийг, дуу чимээ, шуугиан зэрэг ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага зөрчигдөж агаарын бохирдлын нөлөөлөл үзүүлэх болзошгүй. | Агаар дахь хорт бодисын хэмжээг ЗДХ-нээс хэтрүүлэхгүй байх, ажлын байрны агаарын температур, гэрэлтүүлэг, чийглэгийн хэмжээг хянаж, стандартын хэмжээнд байлгах. | Үйлдвэрийн дотор ажлын байранд | Тогтмол хэрэгжүүлж байна | Үйлдвэрийн байрны агааржуулалтын хэвийн ажиллагааг алдагдахаас сэргийлэх үүднээс агааржуулалтын системийг тогтмол шалгаж, бүрэн бүтэн байдлаар нь ажиллуулахад анхааран өвлийн улиралд болзошгүй эрсдлээс сэргийлэн тогтмол засвар үйлчилгээг хийж ажиллав. |

Хүснэгт 2-2. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үйлдвэрийн технологийн усны хэрэглээнээс үүдэн цэвэр усны нөөцөд хомсдол үүсэх эрсдэлтэй | Усны нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэх, хэмнэлттэй ашиглах, технологийг нэвтрүүлэх; | Нойтон боловсруу-лалтын үйлдвэрт | Тогтмол хэрэгжүүлж байна | Үйлдвэрлэлд ашиглаж буй усыг тогтмол бага хэмжээнд барихаар бодын шир боловсруулах шинэ технологи 2022 онд нэвтрүүлж усыг 3 дахин богин арьс боловсруулах шинэ технологи буюу шохой арилгах угаах дамжлагад хэрэглэж буй усыг 4 дахин бууруулж ус бага ашиглах боломжтой болсон. |
| | | Тоолуурын заалтын дагуу цэвэр ус ашигласны болон бохир ус татан зайлуулсны төлбөрийг цаг тухайд нь төлж байх; | Нойтон боловсруу-лалтын үйлдвэрт | Тогтмол хэрэгжүүлж байна | Тогтмол нэхэмжлэхийн дагуу төлж байна. |
| 2 | Хаягдал бохир ус стандартад заасан хэмжээнээс давах, улмаар газрын доорх ус бохирдох сөрөг нөлөө үзүүлэх | Үйлдвэрээс гарч буй ус хаягдал усны стандартад заасан хэмжээнээс давж гарсан тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөр төлөх; | Үйлдвэрээс гарч буй усанд | Тогтмол хэрэгжүүлж байна | Бохир ус урьдчилан цэвэрлэх байгууламжтай. УСУГ болон Харгиа УЦА-наас тавьж буй бүх шаардлагыг биелүүлэн ажиллаж байна. Цэвэрлэх байгууламжинд нийлүүлж буй бохир усны ЗХ-нд хяналтыг УСУГ, мэргэжлийн байгууллага үйл ажиллагаа явуулж буй сарууддад тогтмол хянадаг болно. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | |   |
| | | Механик хольц шүүх сараалж засвар үйлчилгээ | Бохирын шугамын хэмжээгээр | Тогтмол хэрэгжүүлж байна | Механик хольц шүүх сараалж, эргэлтэт 5мм, 3мм шүүүлтүүртэй. Үйлдвэрийн доторх трап шугамууд стандартын дагуу хийгдсэн ба лаг хамагчтай хөдөлгөөнтэй, хөдөлгөөнгүй шүүрүүдийн нэвтрэх чадварыг нарийсгасан, бохир усны гаргалгаан дээр лагыг цэвэрлэж авч байх тогтмол ажилчинг ажиллуулдаг. Үйл ажиллагаа явагдаж буй сард УСУГ-ын инженер, техникийн ажилтнууд хяналт шалгалт тогтмол хийдэг.  |

Хүснэгт 2- 3. Хөрс, ургамлын нөмрөг, эдэлбэр газарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үйлдвэрийн болон ахуйн гаралтай хатуу хог хаягдал, шингэн бохир усаар хөрс бохирдох; | Хөрсний бохирдлын шинжилгээг мэргэжлийн байгууллагаар тогтоосон хугацаанд хийлгэж байх; | Үйлдвэрийн бүсэд | Тогтмол хэрэгжүүлж байна | Хөрсний бохирдлын шинжилгээг мэргэжлийн байгууллагаар тогтоосон хугацаанд хийлгэсэн. Үйлдвэрийн гадна болон дотор бүсэд мэргэжлийн ариутгал халдваргүйтжүүлэлт хийлгэдэг. Зураг хавсаргав. |
| | | Үйлдвэрийн аюултай хог хаягдлыг “Цэцүүх трейд” ХХК-тай хийсэн гэрээний дагуу зайлуулж байх; | Үйлдвэрийн бүсэд | Тогтмол хэрэгжүүлж байна | Аюултай хог хаягдлыг хуримтлуулан Цэцүүх трейд компанитай байгуулсан гэрээний дагуу шилжүүлэх боломжгүй болсон, тус компанийн шатаах зуух эвдэрсэн тул Түмэн эгшиг ХХК-тай гэрээ байгуулан, аюултай хог хаягдлыг шилжүүлсэн. Дагалдах бичиг баримтыг хавсаргав. |
| 2 | Химийн боловсруулах цехийн хойд тал болон механик боловсруулах цехийн зүүн талын шороон зам бүхий газар химийн бодис (хром)-оор бохирдсон | Үйлдвэрийн гадна талбай дахь хромоор бохирдсон хөрсийг саармагжуулах, бохирдлыг бууруулах, цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийж байх; | Үйлдвэрийн бүсэд | Тогтмол хэрэгжүүлж байна | Химийн бодис материалын агуулахын стандартыг мөрдөж ажилладаг ба нэг удаагийн химийн бодисын худалдан авалтын хэмжээг аль болох бага байхаар тооцон бараа материалын татан авалтыг хийж хэвшсэн болно. |
| 3 | Өөрийн эзэмшлийн талбайд зүлэг мод бут тарих | Үйлдвэрийн гадна орчныг зүлэгжүүлэх, цэцэг тарьж тохижуулах | Төслийн талбайд | Тогтмол хэрэгжүүлж байна | Манай компани 2014 онд 20 гаруй модыг тарьсан ба жил бүр арчлан хамгаалж, услаж тордож байна. Зүлэгжүүлсэн талбайн хэмжээ 45м2.<br>Модны ургалт 100 % байна.  Ойжуулалтын гэрээг 2020 онд анх байгуулсан. Энэ ажлын хүрээнд Богд хан уулсын богины аманд 1,5 га-д, 2024 онд Инчоны мөрөөдлийн төгөл цэцэрлэгт хүрээлэнд 1 га газарт мод тарихаар гэрээ байгуулсан. |

## 3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

Компанийн 2014 онд тарьж ургуулсан голт бор 14 ширхэг, 2015-2016 онуудад 2 настай монос 5 ширхэг, үхрийн нүд 2, үрэл 5 ширхэгийг тус тус тарьснаас 100 хувьтай ургаж байгаа болно. 2020 оноос жимсний моднууд бүгд жимсэлж одоо маш өндөр том болж ургасан. Хавар голт бор цэцэглэхэд ойр орчим анхилуун сайхан үнэртэй болдог. Мойл, үрэл жимсний зураг, цэцэглэлтийн зургыг доор үзүүлэв. Зүлэг - 2024 онд зүлэгний үр авч халцарсан газрыг сэргээн зүлэгжүүлсэн. Мод бут, зүлэгний ургалтыг сайжруулах үүднээс шаардлагатай бордоо авч ашигласан. Жимсний ургалт өмнөх жилээс илүү нэмэгдсэн.

2.3.3.1 Компанийн мод бут тарьсан байдал - Нөхөн зүлэгжүүлэлт болон голт борын ургалт хавар цэцэглэж байгаа нь



2.3.3.2 Компанийн мод бут тарьсан байдал – 2015-2016 онуудад тарьсан монос, үхрийн нүд, үрэлний модны ургалт 2018-2019 онуудад





2.3.3.3 Компанийн мод бут тарьсан байдал – 2015-2016 онуудад тарьсан монос, үхрийн нүд, үрэлний модны ургалт 2024 онд



- Дүйцүүлэх арга хэмжээний хувьд 2020 онд “Ногоон Хишигтэн” ТББ- тай Богд хан Уулын дархан цаазат бүс, Богинын амандд 0,5 га талбайд үрээр тарьсан 1 настай шинэсний жижиг суулгац суулгаж ойжуулалт хийхээр гэрээг байгуулсан ба 3 жилийн хугацаанд тордож арчлан ургуулж байлаа.. Энэ ажлаа үргэлжлүүлэн тарих талбайгаа томруулан 2021-2022 онуудад нэмж 1 га газарт нэмж шинэсийн суулгац суулгасан ба гадуур нь торон хашаа татан хамгаалалтын зурвас үүсгэсэн байсан юм. 2022 оны Намрын ургалтын мэдээгээр 80 хувьтай байсан. Гэвч 2023 оны зунаас эхлэн бидний тарьж ургуулж буй тухай талбайд хүрэх аргагүй болоод байна тухайн ам одоо битүү бусдын эзэмшилд шилжсэн бололтой байна. Ногоон Хишигтэн ТББ-гаас гэрээний үүргээ биелүүлэн 2023 онд, 2024 онд Богд хан уулын захиргаанд хүлээлгэн өгөхийг шаардаж байгаа боловч тус байгууллага бидний мэдлээс давсан бид тайлангаа өгсөн одоо ямар ч боломжгүй болчихлоо гэсэн хариу тайлбар өгсөн байдалтай байна. Бидний тарьж ургуулж байсан хамгаалтын тор татаж буй баримтыг тайлангийн хавсралтаас харна уу. 2020 оны гэрээгээр тарьж ургуулсан тайланг “Ногоон Хишигтэн ТББ” БОАЖЯ-нд 2023 онд 3 жилийн гэрээг дүгнэн хүлээлгэн өгсөн гэж мэдэгдсэн. Одоо тэр хэсэг газар бусдын эзэмшилд шилжсэн.

- 2024 онд ойжуулалтын гэрээг Нийслэлийн байгаль орчны газар, Нури ХХК-тай СХД-ын 21-р хорооны нутаг дэвсгэр хуучин хогын цэг байсан одоо Инчоны мөрөөдлийн төгөл цэцэрлэгт хүрээлэнд 1 га газарт мод тарихаар гурвалсан гэрээг 2 жилийн хугацаатай байгуулсан. 2024 оны гэрээний тайланг Нийслэлийн байгаль орчны газар хяналт тавьж байна. Манай компанийн зүгээс шилмүүст мод тарихаар гэрээ хийсэн боловч тус Нүри компани хайлаас тарьсан нь бидний хувьд ойжуулалтын компаниудтай дахин гэрээ хийж ойжуулалт хийлгэхэд итгэл даахгүй байгаа нь ил харагдаж байна. Гэвч НБАГ тайланг хүлээн авсан. Нүри компанийн НБОГ-т хүргүүлсэн тайланг хавсаргав. Цаашид энэ тал дээр холбогдох төрийн байгууллагууд анхаарахыг хүсэж байна.

# 4. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

## 4.1 Төлөвлөгөөний хэрэгжилт

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй | Ажиллагсдын эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд хамгаалах хэрэгслээр хангах; | Үйлдвэрийн технологийн дамжлага бүрт ажиллагсдын хүрээнд | Тогтмол хэрэгжүүлж байна | Ажиллагсдад өдөр бүр хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах хамгаалах хэрэгслийг тавьж олгодог болно. |
| 2 | Эрх зүйн зохицуулалтын дутмаг байдал | Дотоод хяналтын журам боловсруулан батлуулж, түүнийг мөрдөж ажиллах | Нийт үйлдвэрийн хүрээнд | Тогтмол хэрэгжүүлж байна | Дотоод хяналт шалгалтын журам 2015 онд батлагдсан. Дотоод хяналт шалгалтыг 2024 онд төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэж байна. Тайланг хавсаргав.<br>Химийн ослоос урьдчилан сэргийлэх, болзошгүй ослын үед мэргэжлийн аврах ангийг ирэх хүртэлх хугацаанд авах арга хэмжээний төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар батлуулан мөрдөж ажилладаг |
| 3 | Осол дөхөх тохиолдлын болзошгүй нөлөө | Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх | | Тогтмол хэрэгжүүлж байна | |
| 4 | Үйлдвэрийн ослын уршигт байдлын болзошгүй нөлөө | Болзошгүй аваарь ослын үед яаралтай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах, сэлбэх; | | Тогтмол хэрэгжүүлж байна | Яаралтай тусламжийн үед хэрэглэх ахнан шатны тусламжийн багаж хэрэгсэл, эм бэлдмэл бэлэн байдаг. Энэ онд харьцангуй богино хугацаанд ажиллаж байгаа тул хэрэглээ бага байсан. |
| 5 | Гал түймрийн болзошгүй эрсдэл | Гал түймрээс урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд түүнийг шуурхай унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах, сэлбэх; | | Тогтмол хэрэгжүүлж байна | Гал түймрээс урьчдилан сэргийлэх тохиолдолд ашиглах багаж хэрэсэл байнгын бэлэн байдалд байгаа. Гал унтраах хэрэгсэл хүрз 4 ширхэг, галын хор 6 ширхэг, элс 1 тн орчим бэлэн байдалд тогтмол бэлэн байлгаж байна. Дуут дохиолол шинээр авч суурилуулав. |

## 4.2 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хэмжээнд ашиглагдаж байгаа химийн бодис, материалыг бүртгэлжүүлж мэдээллийн санг бүрдүүлэх ажил тогтмолжсон байдаг ба дотоод хяналт шалгалтын журмын дагуу химийн бодисын хадгалалт хамгаалалт, зарцуулалтанд хяналт шалгалтыг тогтмол хийдэг болно. Химийн бодисын эрсдлийн үед авах арга хэмжээний талаар химийн материалтай харьцдаг ажилтнуудад байнга сануулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн эрсдэлээс сэргийлж ажиллаж байна. Байгууллагын химийн материалтай харьцаж ажилладаг ажилтнууд, дотоод шалгалт хариуцсан хяналтын ажилтан, эрсдэл бүхий технологийн нэгжийн ажилтнуудтай хамтран шалгаж эрсдлийн үнэлгээг хийж гүйцэтгэж байна. Химийн бодис материалын агуулахын стандартыг мөрдөж ажилладаг ба агуулахад хадгалж буй химийн бодисийн нэр төрөл болон тоо хэмжээг бууруулахын тулд нэг удаагийн химийн бодисын худалдан авалтын хэмжээг аль болох бага байхаар тооцон бараа материалын татан авалтыг хийх бодлогыг баримтлан хэрэгжүүлж хэвшсэн байсан боловч 2021 оноос эхлэсэн тээвэр логистикийн саатал үнийн өсөлтөөс хамааран импортлон оруулж ирж худалдаалдаг ААН-үүдээс авах боломжгүй болсон, мөн нойтон боловсруулалтанд ус бага хэрэглэдэг шинэ технологи, нэмэлт идээлгэ гүйцээн боловсруулалтын шатанд ногоон сертификат бүхий химийн бодис үйлдвэрлэгч компанийн бүтээгдэхүүнийг ашиглах шаардлагатай болсон тул худалдах худалдан авах гэрээ байгуулан 2022 оноос үйлдвэрлэлд ашиглах ихэнх бодисыг импортлон оруулж ирж байна. Зөвхөн хүхрийн хүчил, шоргоолжны хүчил, антимуф зэрэг бодисыг импортлохгүй бусад компаниас худалдан авдаг болсон. 2024 онд үйл ажиллагаа бараг явуулаагүй тул харьцангуй бага бодис хэрэглэсэн.

Зураг -3.1 Яармаг ХХК-ны 2024 оны химийн материалын бүртгэл

**Химийн материалын бүртгэл - Орлого**

2022 -2024 он

| Он | Байгууллага | Огноо | Цех | Материал | Материалын нэр | Савлагаа | Савлагааны хэмжээ | Сав.тоо.хэм | Нийт хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2024 | Дэлгэрсүх ХХК | 2024-05-06 | Хагас боловсруулалт | Ammonium sulfate | Ammonium sulfate | шуудай | 1 | 50 | 50 |
| 2024 | Мичид Алтай | 2024-05-29 | Хагас боловсруулалт | Цагаан давс | давс | шуудай | 1 | 50 | 50 |
| 2024 | Мичид Алтай | 2024-05-29 | Хагас боловсруулалт | формат натри | формат натри | шуудай | 1 | 25 | 25 |
| 2024 | Нэхий таннери | 2024-06-21 | Нэмэлт идээлгэ | Шоргоолжны хүчил | Шоргоолжны хүчил | сав | 29 | 35 | 1000 |
| 2024 | Мичид Алтай | 2024-07-01 | Нэмэлт идээлгэ | Суурь будаг | хар будаг | хайрцаг | 1 | 40 | 40 |
| 2024 | ДАЙСНЬЮ МОНГОЛИА | 2024-07-03 | Нэмэлт идээлгэ | Суурь будаг | Dyetan G brown BTM | хайрцаг | 1 | 25 | 25 |
| 2024 | ДАЙСНЬЮ МОНГОЛИА | 2024-07-05 | Нэмэлт идээлгэ | Суурь будаг | Burdeos Lorcaflor BV | сав | 1 | 1 | 1 |
| 2024 | ДАЙСНЬЮ МОНГОЛИА | 2024-09-24 | Нэмэлт идээлгэ | Суурь будаг | Pardo Lorcaflor CRB | сав | 1 | 1 | 1 |
| 2024 | ДАЙСНЬЮ МОНГОЛИА | 2024-10-16 | Нэмэлт идээлгэ | Суурь будаг | Rojo LorcaFlor SR | сав | 1 | 0.5 | 0.5 |
| 2024 | Импортолсон | 2024-10-18 | Нэмэлт идээлгэ | Натрийн бикарбонат | Сода | шуудай | 50 | 20 | 1000 |
| 2024 | Импортолсон | 2024-10-18 | Нэмэлт идээлгэ | Гадаргуугын идэвхт бэлдмэл | DOWELLTAN FG-D | сав | 120 | 2 | 240 |
| 2024 | Импортолсон | 2024-10-18 | Нэмэлт идээлгэ | Зөөлрүүлэгч тос | DOWELLOR SH-35 | сав | 120 | 17 | 2040 |
| 2024 | Импортолсон | 2024-10-18 | Нэмэлт идээлгэ | Зөөлрүүлэгч тос | DOWELLOR WP-1 | сав | 120 | 2 | 240 |
| 2024 | Импортолсон | 2024-10-18 | Нэмэлт идээлгэ | Зөөлрүүлэгч тос | DOWELLOR FL-75 | сав | 125 | 3 | 375 |
| 2024 | Импортолсон | 2024-10-18 | Нэмэлт идээлгэ | Зөөлрүүлэгч тос | DOWELLOR FL-79 | сав | 125 | 2 | 250 |
| 2024 | Импортолсон | 2024-10-18 | Хуурай | Лак | DOWELLISH TOP G7218 | сав | 120 | 9 | 1080 |
| 2024 | Импортолсон | 2024-10-18 | Нэмэлт идээлгэ | Идээлэгч бодис | DOWELLTAN A33 | сав | 135 | 3 | 405 |
| 2024 | Импортолсон | 2024-10-18 | Нэмэлт идээлгэ | Дүүргэгч бодис | DOWELLTAN RS16 | сав | 120 | 9 | 1080 |
| 2024 | Импортолсон | 2024-10-18 | Нэмэлт идээлгэ | Суурь будаг | DYES NGP | хайрцаг | 25 | 40 | 1000 |
| 2024 | Импортолсон | 2024-10-18 | Нэмэлт идээлгэ | Суурь будаг | Brown TM | хайрцаг | 25 | 1 | 25 |
| 2024 | Импортолсон | 2024-10-18 | Нэмэлт идээлгэ | Суурь будаг | Brown RTM | хайрцаг | 25 | 1 | 25 |
| 2024 | Импортолсон | 2024-10-18 | Нэмэлт идээлгэ | Суурь будаг | Brown M-RS | хайрцаг | 25 | 1 | 25 |
| 2024 | Импортолсон | 2024-10-18 | Нэмэлт идээлгэ | Суурь будаг | Y/Brown DA | хайрцаг | 25 | 1 | 25 |
| 2024 | Импортолсон | 2024-10-18 | Нэмэлт идээлгэ | Суурь будаг | BEIGE LEN | хайрцаг | 25 | 2 | 50 |
| 2024 | Импортолсон | 2024-10-18 | Нэмэлт идээлгэ | Суурь будаг | HAVANA GA | хайрцаг | 25 | 1 | 25 |
| 2024 | Импортолсон | 2024-10-18 | Нэмэлт идээлгэ | Суурь будаг | Black RD | хайрцаг | 25 | 1 | 25 |

| A | C | D | E | F | G | H | I | J | K | L | M | N | O | P | Q | R | S | T | U | V | W | X | Y | Z | AA | AB |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, технологийн дагуу зарцуулалтын бүртгэл, өдрөөр | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | кг-аар |
| Огноо | Арьс. жин | TRD-WBA | TRD-72 | SEROIL FO | Sertan ALD | Sertan Co | OMPLEX R | SERTAN N-N | SodiumBicarbonate | SEROIL TTK | Dowelltan RE17 | SERTAN VEM | SERTAN VXI | SERTAN VHM | SERTAN VLI | SERTAN ND | SERTAN RD | SERTAN BSP | Dyes | SERTAN DC | SEROIL PLSN | SEROIL SOF | SEROIL LE | SEROIL VS | Dowelltan MPH | FORMIC ACID |
| Гутлын дээд бие 2.2- 2.5 мм | | 0.7 | 0.5 | 1.0 | 1.0 | 1.5 | 0.4 | 2.5 | 0.5 | 6.0 | 1.0 | 5.0 | | | 2.0 | 2.5 | 2.5 | 2.0 | 2.5 | 2.5 | 4.0 | 1.0 | 2.0 | | | 1.2 |
| 4/6/2024 | 1,000 | 7 | 5 | 10 | | | 4 | 25 | 5 | 60 | 10 | 50 | | | 20 | 25 | 25 | 20 | 25 | 25 | 40 | 10 | 20 | | | 12 |
| 4/8/2024 | 1,000 | 7 | 5 | 10 | | | 4 | 25 | 5 | 60 | 10 | 50 | | | 20 | 25 | 25 | 20 | 25 | 25 | 40 | 10 | 20 | | | 12 |
| 4/10/2024 | 1,000 | 7 | 5 | 10 | | | 4 | 25 | 5 | 60 | 10 | 50 | | | 20 | 25 | 25 | 20 | 25 | 25 | 40 | 10 | 20 | | | 12 |
| 4/12/2024 | 1,000 | 7 | 5 | 10 | | | 4 | 25 | 5 | 60 | 10 | 50 | | | 20 | 25 | 25 | 20 | 25 | 25 | 40 | 10 | 20 | | | 12 |
| 4/14/2024 | 1,000 | 7 | 5 | 10 | | | 4 | 25 | 5 | 60 | 10 | 50 | | | 20 | 25 | 25 | 20 | 25 | 25 | 40 | 10 | 20 | | | 12 |
| 10/28/2024 | 1,000 | 7 | 5 | 10 | 10 | 15 | 4 | 25 | 5 | 60 | 10 | 50 | | | 20 | 25 | 25 | 20 | 25 | 25 | 40 | 10 | 20 | | | 12 |
| 11/1/2024 | 1,000 | 7 | 5 | 10 | 10 | 15 | 4 | 25 | 5 | 60 | 10 | 50 | | | 20 | 25 | 25 | 20 | 25 | 25 | 40 | 10 | 20 | | | 12 |
| 11/5/2024 | 1,000 | 7 | 5 | 10 | 10 | 15 | 4 | 25 | 5 | 60 | 10 | 50 | | | 20 | 25 | 25 | 20 | 25 | 25 | 40 | 10 | 20 | | | 12 |
| Нийт | 26,000 | 182 | 130 | 260 | 150 | 225 | 104 | 650 | 130 | 1,560 | 260 | 1,300 | - | - | 520 | 650 | 650 | 520 | 650 | 650 | 1,040 | 260 | 520 | - | - | 312 |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Улны шир, 4 мм | | - | 1.5 | 2.0 | | | | 2.5 | 0.3 | | | 8.0 | 8.0 | 8.0 | | 3.5 | 2.5 | | 2.0 | 2.5 | | | | 1.5 | 1.5 | 1.0 |
| 1/6/2024 | 1,000 | - | 15 | 20 | - | - | - | 25 | 3 | - | - | 80 | 80 | 80 | - | 35 | 25 | - | 20 | 25 | - | - | - | 15 | 15 | 10 |
| 2/6/2024 | 1,000 | - | 15 | 20 | - | - | - | 25 | 3 | - | - | 80 | 80 | 80 | - | 35 | 25 | - | 20 | 25 | - | - | - | 15 | 15 | 10 |
| 3/26/2024 | 1,000 | - | 15 | 20 | - | - | - | 25 | 3 | - | - | 80 | 80 | 80 | - | 35 | 25 | - | 20 | 25 | - | - | - | 15 | 15 | 10 |
| 4/6/2024 | 1,000 | - | 15 | 20 | - | - | - | 25 | 3 | - | - | 80 | 80 | 80 | - | 35 | 25 | - | 20 | 25 | - | - | - | 15 | 15 | 10 |
| 7/6/2024 | 1,000 | - | 15 | 20 | - | - | - | 25 | 3 | - | - | 80 | 80 | 80 | - | 35 | 25 | - | 20 | 25 | - | - | - | 15 | 15 | 10 |
| 10/30/2024 | 1,000 | - | 15 | 20 | - | - | - | 25 | 3 | - | - | 80 | 80 | 80 | - | 35 | 25 | - | 20 | 25 | - | - | - | 15 | 15 | 10 |
| 11/7/2024 | 1,000 | - | 15 | 20 | - | - | - | 25 | 3 | - | - | 80 | 80 | 80 | - | 35 | 25 | - | 20 | 25 | - | - | - | 15 | 15 | 10 |
| Нийт | 7,000 | - | 105 | 140 | - | - | - | 175 | 21 | - | - | 560 | 560 | 560 | - | 245 | 175 | - | 140 | 175 | - | - | - | 105 | 105 | 70 |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Дотуур улны шир, 2 мм | | - | 1.5 | 2.0 | | | | 2.5 | 0.3 | | | 8.0 | 8.0 | 8.0 | | 3.5 | 2.5 | | 2.0 | 2.5 | | | | 1.5 | 1.5 | 1.0 |
| 1/26/2024 | 1,000 | - | 15 | 20 | - | - | - | 25 | 3 | - | - | 80 | 80 | 80 | - | 35 | 25 | - | 20 | 25 | - | - | - | 15 | 15 | 10 |
| 2/26/2024 | 1,000 | - | 15 | 20 | - | - | - | 25 | 3 | - | - | 80 | 80 | 80 | - | 35 | 25 | - | 20 | 25 | - | - | - | 15 | 15 | 10 |

Хүснэгт -3.1 Яармаг ХХК-ны 2024 оны химийн материалын ашиглалт, үлдэгдлийн тайлан

| № | Химийн материал | 2023 оны 12-р сарын 31-ны өдрийн үлдэгдэл | | | | 2024 оны 12-р сарын 06-ны өдрийн үлдэгдэл | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Худалдан авсан | Импортол-сон | Зарцуул-сан | Үлдэгдэл | Худалдан авсан | Импортол-сон | Зарцуул-сан | Үлдэгдэл |
| 1 | Натрийн сульфид | 15.00 | - | 9.80 | 20.00 | | - | 5.38 | 14.63 |
| 2 | Аммонийн сульфат | 4.00 | - | 8.30 | - | 0.35 | - | 0.35 | - |
| 3 | Хүхрийн хүчил | 5.60 | | 10.00 | - | | | | - |
| 4 | Хромын сульфат | | 53.50 | 48.80 | 5.00 | | | 1.50 | 3.50 |
| 5 | Антимуф, Бактерустгагч | 0.72 | | 2.52 | - | | | | - |
| 6 | Дэвтээгч бодис | - | - | 6.30 | 1.30 | - | - | 0.30 | 1.00 |
| 7 | Тос авагч | - | | 4.40 | - | - | 0.24 | 0.24 | - |
| 8 | Шингэн саван | - | | 3.20 | 1.00 | - | 1.75 | 1.75 | 1.00 |
| 9 | Энзим | - | | - | - | - | | | - |
| 10 | Шохойдлогын туслах материал | - | 0.96 | 6.44 | 0.12 | - | | | 0.12 |
| 11 | Шохой арилгагч, туслах бодис | - | | 5.10 | 2.50 | - | | 0.25 | 2.25 |
| 12 | Суурилаг өндөржүүлэгч | 0.30 | 3.70 | 4.40 | 1.50 | | | 1.00 | 0.50 |
| 13 | Техникийн сод | 0.10 | 1.50 | 1.45 | 0.25 | | 3.00 | 2.20 | 1.05 |
| 14 | Хром синтан | - | - | 0.50 | - | - | - | | - |
| 15 | Зөөлрүүлэгч тос | 0.48 | 5.26 | 9.03 | 0.61 | | 14.36 | 10.36 | 4.61 |
| 16 | Дүүргэгч бодис | - | 0.84 | 0.72 | 0.12 | | 1.73 | 1.40 | 0.45 |
| 17 | Суурь будаг | 0.09 | 0.93 | 1.21 | 0.50 | 0.07 | 2.33 | 2.00 | 0.89 |
| 18 | Пигмент | 0.14 | 1.65 | 0.70 | 1.09 | | 0.03 | 0.70 | 0.42 |
| 19 | Гүйцээн боловсруулах бэлдмэл | - | 11.39 | 11.09 | 1.00 | | 3.27 | 3.02 | 1.25 |
| 20 | Бэхжүүлэгч лак | - | - | 0.20 | - | | 1.08 | 0.80 | 0.28 |
| 21 | Идээлэгч бодис, | - | 13.80 | 13.00 | 4.90 | | 15.46 | 14.90 | 5.46 |
| 22 | Хурган чихний хүчил | 0.03 | - | 0.10 | 0.03 | | | | 0.03 |
| 23 | Шорголжны хүчил | 1.68 | - | 2.20 | 0.68 | 2.00 | | 2.20 | 0.48 |
| | Дүн | 28.13 | 93.52 | 149.46 | 40.60 | 2.42 | 43.24 | 48.35 | 37.91 |

* Дархан-Нэхий ХХК, Цэцүүх трейд ХХК, Дайс Нью ХХК-наас худалдан авалт хийдэг болно

Хадгалалтын орчинд гэрэлтүүлэг болон агааржуулалтын систем нь хангалттай ажиллаж буйг байнга шалгаж, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна.

## 5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйлдвэрийн дотор хатуу хог хаягдлыг хогийн цэг рүү ачихаас өмнө түр хуримтлуулах савтай ба уг цэгийг байнгын сайжруулж, шингэн лагыг хуримтлуулан шингэнийг шүүрүүлсний дараа хогыг тогтмол ачиж хаяж байна.

Манай компани үйлдвэрлэлийн хог хаягдал өөрсдийн унаагаар тээвэрлэн зориулалтын хогын цэгт хүргэн ажилладаг болно.

Арьс шир боловсруулах үйлдвэрлэл улирлын чанартай үйл ажиллагаа тул өвөл, хаврын улиралд гол төлөв ажилладаг. Хог хаягдал хаясан болон бүртгэл мэдээг дор харуулав.

Үйлдвэрлэлийн энгийн, ахуйн хог хаягдал хаях, шилжүүлэх гэрээг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-тай байгуулан ажиллаж байна. Гэрээгээр манай компани өөрийн унаагаар Хан-Уул дүүргийн Морингийн давааны төвлөрсөн хогийн цэгт буулгах ба Хот тохижилтын газар хэмжилт хийн, ландфилл хийхээр гэрээнд зохицуулагдсан болно.

Байгууллагын гаднах орчны их цэвэрлэгээг (үйлдвэрийн болон оффисын барилгын гаднах нийтийн эзэмшлийн зам талбайн) үйл ажиллагаа явуулж буй сард 2 удаа хийдэг ба 4-р сард цас хайлсны дараа, 10,11-р сарууддад мод бут навчис гөвсний дараа байгууллагын ойр орчмын нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэхэд их хэмжээтэй хог хаягдал гардаг ба мөн өөрийн унаагаар хогын цэгт тээвэрлэн хүргэж ажилладаг. Энэ жил Монгол шир ХХК-ны хуучирсан замыг засч янзлахад болон өмнөх жил арьс ширний үйлдвэрийн хашаанд автомашины замыг шинэчлэн тавьсан зэрэг ажлын хүрээнд хуучин явган хүний замыг хуулсан үйлдвэрийн ойр орчимд цемент чулууны хог хаягдал үүссэнг мөн өөрийн унаагаар зөөж тээвэрлэн зайлуулсан болно.

Үйлдвэрийн аюултай хог хаягдлыг шилжүүлэх гэрээг Цэцүүх трейд компанитай 2019 онд байгуулсан ба энэхүү гэрээгээр тус компанийн аюултай хог хаягдлыг шилжүүлдэг байсан боловч 2024 онд тус компанийн шатаах зууханд асуудал гарсан. Иймээс Түмэн эгшиг ХХК-тай шинээр гэрээ байгуулан хог хаягдлыг устгуулахаар шилжүүлсэн болно.

Хүснэгт-5.1 Хог хаягдал тээвэрлэн хүргэсэн тоо хэмжээ

| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 8 | 9 | 11 | 12 | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ахуйн хог хаягдал | | 3.7 | 6.2 | 14.9 | 12.4 | - | - | 5.1 | 33.5 | 4.2 | - | 80.0 |
| Барилгын хог хаягдал | | - | - | - | - | - | - | 26.7 | 12.1 | - | - | 38.9 |
| Мал амьтны гаралтай хог | | 45.0 | 49.5 | 123.7 | 93.3 | 12.0 | 7.5 | - | - | - | - | 331.0 |
| **Нийт** | Хэмжээ тн. | 48.7 | 55.7 | 138.6 | 105.8 | 12.0 | 7.5 | 31.8 | 45.6 | 4.2 | - | 449.9 |

Хүснэгт-5.2 Хог хаягдал тээвэрлэн төвлөрсөн хогын цэгт хүлээлгэн өгсөн бүртгэлээс

Хог ачилтын бүртгэл

| | | | | | 2024 он |
|---|---|---|---|---|---|
| № | Хог, хаягдлын төрөл | Огноо | Хогны жин | Машины жин | Нийт жин |
| 1 | Ахуйн хог хаягдал | 2024.01.11 | 3.69 | 12.05 | 15.74 |
| 2 | Мал, амьтны гаралтай хог | 2024.01.18 | 10.45 | 12.05 | 22.5 |
| 3 | Мал, амьтны гаралтай хог | 2024.01.21 | 19.27 | 12.05 | 31.32 |
| 4 | Мал, амьтны гаралтай хог | 2024.01.30 | 15.31 | 12.05 | 27.36 |
| 5 | Мал, амьтны гаралтай хог | 2024.02.05 | 12.05 | 12.05 | 24.1 |
| 6 | Мал, амьтны гаралтай хог | 2024.02.17 | 21.43 | 12.05 | 33.48 |
| 7 | Ахуйн хог хаягдал | 2024.02.18 | 6.23 | 12.05 | 18.28 |
| ... | | | | | |
| 19 | Мал, амьтны гаралтай хог | 2024.04.09 | 14.83 | 12.05 | 26.88 |
| 20 | Мал, амьтны гаралтай хог | 2024.04.11 | 17.25 | 12.05 | 29.3 |
| 21 | Мал, амьтны гаралтай хог | 2024.04.16 | 13.51 | 12.05 | 25.56 |
| 22 | Мал, амьтны гаралтай хог | 2024.04.20 | 15.65 | 12.05 | 27.7 |
| 23 | Мал, амьтны гаралтай хог | 2024.04.28 | 14.51 | 12.05 | 26.56 |
| 24 | Ахуйн хог хаягдал | 2024.04.29 | 12.43 | 12.05 | 24.48 |
| 25 | Мал, амьтны гаралтай хог | 2024.05.04 | 12.03 | 12.05 | 24.08 |
| 26 | Мал, амьтны гаралтай хог | 2024.06.25 | 7.47 | 12.05 | 19.52 |
| 28 | Барилгын хог хаягдал | 2024.08.05 | 10.94 | 14.5 | 25.44 |
| 29 | Ахуйн хог хаягдал | 2024.08.13 | 5.1 | 14.5 | 19.6 |
| 30 | Барилгын хог хаягдал | 2024.08.25 | 15.8 | 14.5 | 30.3 |
| 31 | Ахуйн хог хаягдал | 2024.09.06 | 8.46 | 14.5 | 22.96 |
| 32 | Ахуйн хог хаягдал / Нийтийн эзэмшлийн зам талбай цэвэрлэснээс гарсан | 2024.09.06 | 11.52 | 14.5 | 26.02 |
| 33 | Барилгын хог хаягдал | 2024.09.07 | 12.12 | 14.5 | 26.62 |
| 34 | Ахуйн хог хаягдал / Нийтийн эзэмшлийн зам талбай цэвэрлэснээс гарсан | 2024.09.08 | 12.52 | 14.5 | 27.02 |
| 35 | Ахуйн хог хаягдал | 2024.09.21 | 0.96 | 14.5 | 15.46 |

Хүснэгт-5.3 Аюултай хог хаягдал шилжүүлсэн бүртгэл

| № | Он | Шилжүүлсэн огноо | Төрөл | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Тээврий хэрэгсэл | Хүлээн авсан |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2020 | 2020-06-09 | Шуудай | кг | 730 | 27-76 УАА | Цэцүүх трейд ХХК |
| 2 | 2021 | 2021-09-09 | Шуудай | кг | 632 | 27-76 УАА | Цэцүүх трейд ХХК |
| 3 | 2021 | 2021-09-09 | Сав | ш | 13 | 27-76 УАА | Цэцүүх трейд ХХК |
| 4 | 2022 | 2022-12-30 | Шуудай | кг | 173 | 27-76 УАА | Цэцүүх трейд ХХК |
| 5 | 2022 | 2022-12-30 | Сав | ш | 4 | 27-76 УАА | Цэцүүх трейд ХХК |
| 6 | 2023 | 2023-02-03 | Шуудай | кг | 284 | 27-76 УАА | Цэцүүх трейд ХХК |
| 7 | 2024 | 2024-10-25 | Шуудай | кг | 450 | 18- 14 УБМ | Түмэн эгшиг ХХК |

Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар - 200210

# 6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | **Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа** | **Хэрэгжилт** |
|---|---|---|---|
| | 1. | 2. | 3. |
| 1 | Бохирдлын цэгэн эх үүсвэр:<br>- Нүүрстөрөгч<br>- Хүхэрт устөрөгч<br>- Азотын давхар исэл<br>- Хүхэрлэг хий /SO2/<br>- Нийт тоосны агууламж /TSP/ | Бүрэн хэрэгжсэн | <br>ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР<br>БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ<br>СОРИЛТЫН ДҮН<br>Агаарын чанарын шинжилгээ, ажлын байрны дуу шуугиан, хөрсөн дэхь хүнд металлуудын агууламж, хөрсний ялзмагын шинжилгээг 2024 онд үйл ажиллагаа явуулж буй сар 5-р сард Цаг уур орчны шинжилгээний газрын Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторoор хийлгүүлсэн. |
| 2 | Ажлын байрны дуу шуугиан | Бүрэн хэрэгжсэн | |
| 3 | Гадаргын болон газар доорх усны чанар:pH, усны түвшин, TDS (нийт ууссан давс), нийт хатуулаг (CaCO3), ууссан хүчилтөрөгч, умбуур, БХХ, ХХХ | Бүрэн хэрэгжсэн | <br>Бохир усны шижилгээг нойтон цехийн үйл ажиллагаа явуулж буй үед УСУГ-аас өөрсдөө ирж дээж авч, тогтмол хяналт тавьж ажилладаг. |
| 4 | Хөрсөн дэх хүнд металлуудын агууламжийг тодорхойлох | Бүрэн хэрэгжсэн | <br>ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР<br>БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ<br>СОРИЛТЫН ДҮН<br><br>ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР<br>БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ<br>СОРИЛТЫН ДҮН |

## 7. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | **Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа** | **Хэрэгжилт** |
|---|---|---|---|
| | 4. | 5. | 6. |
| 1 | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх шинэчлэн засварлах | Тогтмол хэрэгжүүлж байна | Байгууллагын дотоод журам 2015 онд батлагдсан, уг журмын дагуу дотоод хяналт шалгалтыг тогмиол хийж хэрэгжүүлдэг |
| 2 | Байгаль орчныг хамгаалах, осол аваар , гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт, судалгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах | Бүрэн хэрэгжсэн | Сургалтыг 5-р сард зохион байгуулсан, Зургыг хавсралтаас үзнэ үү |
| 3 | Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ-т хүргэн өгч байх | Төлөвлөж байна | 12-р сард багтаан ХУД-ын ИТХ болон БОАЖЯ-нд хүргүүлнэ |
| 4 | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээг зохион байгуулах | Тогтмол хэрэгжүүлж байна | Ажиллагсдын хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд ажиллагсдын амралтын өрөөг засварласан. Угаалгын машин эвдэрсэнг шинээр авч тавьсан. Ажиллагсад өдөр бүр усанд ордог тул, цэвэрлэгээг тогтмол хийлгэдэг. |
| 5 | Бүх ажиллагсдыг жилд 1 удаа нарийн мэргэжлийн эмч нарт хамруулж байх | 12 сард төлөвлөж байна. | Ажиллагсад 5- сараас эхлэн сул зогсолттой байгаа тул 12 сард хийхээр төлөвлөж байна |
| 6 | Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах , галын аюулгүй ажиллагааны самбар шинэчлэх | Тогтмол хэрэгжүүлж байна | Галын аюулгүй ажиллагааны хуучин самбарыг шинэчлэв. |
| 7 | ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах | Тогтмол хэрэгжүүлж байна | Үйл ажиллагаа явуулж байгаа үед өдөр бүр ХАБ-ийн заавар заарчилгааг тогтмол өгч, болзошгүй эрсдлээс хамгаалан ажииллаж байна. |
| 8 | Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангах | Тогтмол хэрэгжүүлж байна | Ажиллагсдад олгох хөдөлмөр хамгааллын хэрэгслийг олгох тушаал шийдвэр батлагдсан төвийн дагуу өдөр бүр олгодог. |
| | | | |

# 8. ДҮГНЭЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгасан ажлуудын хэрэгжилтийн үнэлгээг талуудад ойлгомжтой болгох, хялбаршуулах зорилгоор төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлын зорилго тус бүрт гүйцэтгэлийн шалгуур тавьж тухайн ажлын цар хүрээ, зардлаас хамааралтай дэд төлөвлөгөөнд эзлэх хувийг тодорхойлов.

| Ангилал | Арга хэмжээ | Биелэлтийн шалгуур | Эзлэх хувь | Гүй-цэтгэл |
|---|---|---|---|---|
| Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах | Үйлдвэрийн доторх бохир усны трап шугамуудад тавигдсан шүүрүүд, бохир усны гаргалгаан дээрх тогтмол цэвэрлэж авдаг ба зөвхөн энэ ажлыг хариуцсан ажилчинг ажиллуулж агаарт бохир уснаас гарах үнэрийг багасгаж ажилласан | Ажиллагчдын эрүүл ажиллах нөхцөл, агаарт бохир уснаас үүдэн гарах үнэр багассан байна | 25 | 100 |
| | Арьсны тосыг бүрэн авч, ургамлын идээлгийг нэмэлт идээлгийн түвшинд тогтмол ажиллаж байна. Технологид Испанийн Quimser компанийн бүтээгдэ-хүүнийг хэрэглэж байна. Тус компани нь ОУ-ын стандарт ZDHC түвшин 2,3-ыг хангасан мөн Европын REACH журамд нийцүүлсэн бүтээгдэхүүн үйлвэрлэдэг. | Арьс боловсруулах технологиос шалтгаалан агаарт бохирдол үүсгэхээс сэргийлж ажилласан байна | 25 | 100 |
| | Химийн бодис материалын хадгалалтын нөхцлийн стандартыг нарийн баримтлах уурших, халах, тэлэх нөхцөлөөс бүрэн сэргийлж ажилласан | Химийн бодисоос агаарт хорт хий ялгаруулахаас сэргийлсэн байна | 25 | 100 |
| | Үйлдвэрийн байрны агааржуулалтын хэвийн ажиллагаар алдагдахаас сэргийлэх үүднээс агааржуулалтын системийг тогтмол шалгаж, бүрэн бүтэн байдлаар нь ажиллуулахад анхааран өвлийн улиралд болзошгүй эрсдлээс сэргийлэн тогтмол засвар үйлчилгээг хийж ажиллав. | Агаар дахь хорт бодисын хэмжээг ЗДХ-нээс хэтрүүлээгүй, ажлын байрны агаарын температур, гэрэлтүүлэг, чийглэгийн хэмжээ стандартын хэмжээнд байлгаж ажилласан. | 25 | 100 |
| Хөрсний чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах | Хөрсийг үйлдвэрлэлийн хог хаягдлаар бохирдуулахгүй байхад анхаарч ажилласан ба үйлдвэрийн дотор байгуулсан хатуу хог хаягдлыг хуримтлуулах цэгийн байнгын сайжруулалтыг хийж, хогыг тогтмол ачиж хаясан. Үйлдвэрт ашиглаж химийн бодисын сав баглаа 450кг аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагад шилжүүлэн устгуулсан. | Хөрс бохирдохоос хамгаалсан байна | 40 | 100 |
| | Бохир ус халихаас сэргийлж, бохир усны худгыг байнгын засаж, орчныг цэвэрлэж ариутгаж байв. | Хөрсны бохирдлоос сэргийлж ажилласан байна | 30 | 100 |
| | Ногоон байгууламжын арчилгаа – компанийн тарвсан мод бутыг байнга услаж тордож ажилласан. Мөн халцарсан зүлгийг сэргээж шинээр хар шороон хөрс асган зүлэг тарив. Мод бут, зүлэгний ургалтыг сайжруулах зорилгоор мэргэжлийн байгууллагаас бордоо авч ургалтын сард 2 удаа бордсон. | Агаар, хөрсний чанар сайжирна | 30 | 100 |
| Усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах | Үйлдвэрлэлд ашиглаж буй усыг тогтмол бага хэмжээнд барихаар арьс боловсруулах шинэ технологи 2022-2023 онуудад нэвтрүүлсэн ба өмнө хэрэглэж байснаас 3 дахин бага ус ашиглах боломжтой болсон. | Усыг хэмнэлттэй ашигласан байна. | 20 | 100 |
| | Харьяа байгууллагатай ус ашиглах гэрээ байгуулж ус ашигласны төлбөр төлөх, цэвэх болон бохир ус зайлуулсан төлбөрийг нэхэмжлэхийн дагуу цаг хугацаанд төлсөн | Ус ашиглах дүгнэлт, Ус ашиглах гэрээ байгуулж, ус ашигласны төлбөр | 20 | 100 |
| | Хаягдал усыг зайлуулах шугам, трап, тунгаагуурын цэвэрлэгээ засвар үйлчилгээ тогтмол хийж, хяналт тавьж ажилласан. Бохир | Үйлдвэрээс гарч буй бохир ус хаягдал усны | 60 | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | ус урьдчилан цэвэрлэх байгууламжтай. УСУГ болон Харгиа УЦА-наас тавьж буй бүх шаардлагыг биелүүлэн ажиллаж байна. Цэвэрлэх байгууламжинд нийлүүлж буй бохир усны ЗХ-нд байгаа эсэх хяналтыг УСУГ -аас үйл ажиллагаа явуулж буй саруудад тогтмол явуулдаг бохир усны шинжилгээг УСУГ-ын харъяа лабароторит тогтмол хийлгүүлсэн. | стандартад нийцсэн байна | | |
| Хог хаягдлийн менежмент | Үйлдвэрийн дотор хатуу хог хаягдлыг хогийн цэг рүү ачихаас өмнө түр хуримтлуулах савтай ба уг цэгийг байнгын сайжруулж, шингэн лагыг хуримтлуулан шингэнийг шүүрүүлсний дараа хогыг тогтмол ачиж хаяж байна. Хатуу хог хаягдлыг өөрсдийн унаагаар тээвэрлэн зориулалтын хогын цэгт хүргэн ажилладаг болно. Үйлдвэрлэлийн энгийн, ахуйн хог хаягдал хаях, шилжүүлэх гэрээг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-тай байгуулан ажиллаж байна. Гэрээгээр манай компани өөрийн унаагаар Хан-Уул дүүргийн Морингийн давааны төвлөрсөн хогийн цэгт буулгах ба Хот тохижилтын газар хэмжилт хийн, ландфилл хийхээр гэрээнд зохицуулагдсан болно.Байгууллагын гаднах орчны их цэвэрлэгээг (үйлдвэрийн болон оффисын барилгын гаднах нийтийн эзэмшлийн зам талбайн) үйл ажиллагаа явуулж буй сард 2 удаа хийдэг ба энэ жил 4-р сард цас хайлсны дараа, 9, 10-р сард мод бут навчис гөвсний дараа байгууллагын ойр орчмын нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэж мөн өөрийн унаагаар хогын цэгт тээвэрлэн хаясан. | Жилийн турш | 80 | 100 |
| | Үйлдвэрийн аюултай хог хаягдлыг шилжүүлэх гэрээг Түмэн эгшиг ХХК-тай шинээр гэрээ байгуулан хог хаягдлыг устгуулахаар шилжүүлсэн | Ашигласан бодисын сав баглаа боодлыг устгуулахаар шилжүүлэх | 20 | 100 |
| Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | Агаарын чанарын хяналт, шинжилгээ | Агаарын чанар ерөнхий шаардлагын хэмжээнд байх | 25 | 100 |
| | Ажлын байрны дуу чимээний шинжилгээ | ХААЭА, Дуу чимээ хэвийн норм, түвшний хэмжээнд байх | 25 | 100 |
| | Хөрсний чанарын хяналт, шинжилгээ | Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээнд байх | 25 | 100 |
| | Бохир усны хяналт | Харгиа УЦБ-нд нийлүүлэх техноло-гийн хаягдал усны шаардлагад нийцсэн байх | **25** | **100** |

## 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн нийт зардал

| **№** | ***Бүрэлдэхүүн хэсгүүд*** | ***Төлөвлөсөн зардал/мян.т/*** | ***Бодит зардал /мян.т/*** |
|---|---|---|---|
| ***1*** | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 2125,0 | 4,795,3 |
| ***2*** | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 2275,0 | 400,0 |
| ***3*** | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 835,0 | 838,7 |
| ***4*** | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 484,0 | 258,3 |
| ***5*** | Удирдлага зохион байгуулалт | 1 600,0 | 1638,5 |
| | *Нийт* | **7 319,0** | **7930,8** |

# 9. ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТУУД

## 9.1. Дүйцүүлэх арга хэмжээ болон тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд

**ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨР МОД ТАРИХ**
**ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2024 оны 7 дугаар сарын 1 Дугаар: 50Г/2024-35 Улаанбаатар хот

**Санхүүжүүлэгч талаас:** Улсын бүртгэлийн 9011470088, регистрийн 2595117 тоот дугаартай "Ярмаг" ХХК, түүнийг төлөөлж захирал Б.Нямцэрэн /цаашид "Санхүүжүүлэгч тал" гэх/,

**Зөвлөх талаас:** Улсын бүртгэлийн 9070001047 регистрийн 9077049 тоот дугаартай Нийслэлийн Байгаль орчны газар, түүнийг төлөөлж газрын дарга Р.Энхтайван /цаашид "Зөвлөх тал" гэх/,

**Гүйцэтгэгч талаас:** Улсын бүртгэлийн 9011064069, регистрийн 2781085 тоот дугаартай "Нүри" ХХК төлөөлж захихал Х.Лхагважав /цаашид "Гүйцэтгэгч тал" гэх хамтад нь "Талууд" гэх/ нар нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 30, 31 дүгээр зүйл, Ойн тухай хуулийн 22, 23 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 2010 оны 63 дугаар зарлиг, "Засгийн газарт чиглэл өгөх тухай" 2021 оны 58 дугаар зарлиг, Монгол Улсын засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний талаарх авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай төлөвлөгөөний 33 дугаар заалт, Сангийн сайд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А96/71 дугаартай тушаалаар батлагдсан "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх" журмын 3 дугаар зүйлийн 3.3.3 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн 21 дугаар хорооны нутаг дэвсгэр Жаргалант тосгоны хуучин хогийн цэг хүйн гол дагуу хамгаалалтын ойн зурвас байгуулах ажил гүйцэтгүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахаар тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 **Гэрээний зорилго:** Энэхүү гэрээгээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж нэмэгдүүлэх, цөлжилт газрын доройтолд орсон талбайн экологийн тэнцвэрт байдлыг хангах, байгаль орчны хамгаалалд бодитой хувь нэмэр оруулах зорилгоор талууд гэрээнд заасан нөхцөлөөр хамтарч ажиллахтай холбогдон үүсэх бүхий л харилцааг зохицуулна.

1.2 **Гэрээний зүйл:** Талууд гэрээнд заасан хугацаанд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн дор дурдсан байдлаар хамтран ажиллана. Үүнд:

1.2.1 Санхүүжүүлэгч нь Сонгинохайрхан дүүргийн 21 дугаар хорооны нутаг дэвсгэр Жаргалант тосгоны хуучин хогийн цэг хүйн гол дагуу хамгаалалтын ойн зурвас байгуулах ажилд бодитой хувь нэмэр оруулах зорилгоор гэрээний Хавсралт №1-т заасан талбайг ойжуулах, нөхөн сэргээх, ургуулах, хамгаалах (хашаалах) /цаашид "гэрээний зүйл" эсвэл "гэрээт ажил" гэх/-г санхүүжүүлэх.

1.2.2 Зөвлөх тал нь гэрээнд заасан нөхцөлийн дагуу гэрээт ажлыг хийж гүйцэтгэхэд чиглэл, зөвлөмж өгч гэрээнд заасан нөхцөлөөр талуудтай хамтран ажиллана.

1.2.3 Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний Хавсралт №1-т заасан талбайд гэрээт ажлыг санхүүжүүлэгч болон зөвлөгч талуудын шаардлагад нийцүүлэн чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн акт үйлдэж, хүлээлгэн өгнө.

Талуудын баталгаат гарын үсэг

Санхүүжүүлэгч: ..................... Зөвлөх: ..................... Гүйцэтгэгч: .....................

НҮРИ ХХК

1.3 **Гэрээний зарчим:** Талууд хамтын ажиллагаандаа хууль дээдлэх, байгууллага хоорондын харилцааны зохистой хэмжээг баримтлан харилцан санал солилцох, зөвшилцөх, эрх тэгш байдлыг эрхэмлэх, талууд нээлттэй, ил тод байх, үр бүтээлтэй хамтран ажиллах зарчмуудыг баримтална.

1.4 **Гэрээний хугацаа:** Энэхүү гэрээ нь 2024 оны 05-р сарын 25-ны өдрөөс 2025 оны 10-р сарын 25-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

1.5 **Гэрээний хавсралт:** Энэхүү гэрээ нь дараах хавсралтуудаас бүрдэх ба эдгээр нь гэрээний салшгүй хэсэг болно.

1.5.1 Хавсралт №1 - Гэрээт ажлыг хийж гүйцэтгэх талбайн байршил

1.5.2 Хавсралт №2 - Зөвлөх талаас бэлтгэсэн Гэрээт ажлын хуваарь, техникийн тодорхойлолт

1.5.3 Хавсралт №3 - Талбайд хийгдэх гэрээт ажлын зардал

1.6 **Гэрээт ажлын үр дүн хүлээлцэх:**

1.6.1 Зөвлөгч тал нь гүйцэтгэгчийн ажлын тайлан ажлын үр дүнтэй бодитой нийцэж буй эсэхийг ажлын хуваарь болон даалгаврын дагуу шалгаж, шаардлагад нийцсэн гэж үзсэн тохиолдолд Сангийн сайд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А96/71 дугаартай тушаалаар батлагдсан "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, тарималь ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх" журмын 4 дүгээр хавсралтын дагуу "Ойн зурвас байгуулсан ажлыг хүлээж авах акт" үйлдэж, санхүүжүүлэгчид хүргүүлнэ.

1.6.2 Гэрээт ажлын үр дүн шалгах явцад мөн гэрээнд заасан баталгаат хугацаанд доголдол илэрсэн тохиолдолд гүйцэтгэгч нь өөрийн зардлаар зөвлөх тал эсвэл санхүүжүүлэгч талуудаас тогтоосон хугацаанд доголдолыг арилгана. Доголдолыг заасан хугацаанд арилгаагүй тохиолдолд гэрээний хугацааг хэтрүүлсэнд тооцно.

1.7 **Баталгаат хугацаа:**

1.7.1 Гүйцэтгэгч нь ойн зурвас байгуулсан талбайгаа 3 жилийн хугацаанд арчлан хамгаалж ургуулах ажлыг бүрэн хариуцна.

1.7.2 Баталгаат хугацаанд гэрээт ажлын үр дүнд доголдол үүссэн тохиолдолд гүйцэтгэгч нь санхүүжүүлэгч болон зөвлөх талын тогтоосон хугацаанд багтаан арилгаж, энэхүү доголдолыг арилгахтай холбогдсон бүхий л зардал үл маргах журмаар бүрэн хариуцна.

## ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

2.1 **Гэрээний үнэ:** Хавсралт №3-т заасны дагуу гэрээний нийт үнэ **8,242,500₮** (Найман сая хоёр зуун дөчин хоёр мянга таван зуу) төгрөг байна. Уг дүнд НӨАТ, ААНОАТ, тээврийн зардал болон гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай бүхий л зардлууд багтсан болно.

2.2 **Төлбөрийн нөхцөл:**

2.2.1 Гэрээний нийт төлбөрийн 50 хувь буюу **4,121,250₮** (Дөрвөн сая нэг зуун хорин нэгэн мянга хоёр зуун тавин) төгрөгийг, гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор гүйцэтгэгчээс ирүүлсэн нэхэмжлэх, НӨАТ-ын баримтыг үндэслэн Гүйцэтгэгч талд шилжүүлнэ.

2.2.2 Гэрээний нийт төлбөрийн 50 хувь төлбөр буюу **4,121,250₮** (Дөрвөн сая нэг зуун хорин нэгэн мянга хоёр зуун тавин) төгрөгийг Зөвлөх талын хяналтан дор тарьсан тарьцыг тоолсон акт, гэрээний Хавсралт №2-т заасан хугацаанд арчилгаа хийж гэрээний эхний жилийн ажлыг дүгнэн акт үйлдсний дараа гүйцэтгэгчээс ирүүлсэн нэхэмжлэх, НӨАТ-ын баримтыг үндэслэн 2025 оны 3-р сарын 30 ний дотор Гүйцэтгэгч талд шилжүүлнэ.

Талуудын баталгаат гарын үсэг

Санхүүжүүлэгч: .................... Зөвлөх: .................... Гүйцэтгэгч: ....................

НҮРИ ХХК

хэрэгжүүлэхийн тулд нөгөө талд мэдэгдэх шаардлагатай тохиолдолд гэрээ хүчин төгөлдөр болсны дараа нууц мэдээллийг дамжуулна.

5.12 **Мэдээллийн аюулгүй байдлын шаардлага:** Санхүүжүүлэгч нь MNS ISO/IEC 27001:2023, ISO/IEC 27701:2019 олон улсын стандартуудын дагуу мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, Хувийн мэдээллийн удирдлагын тоголцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлэн мөрдөж байгааг талуудойлгож байгаа бөгөөд үүнтэй холбоотой зохих шаардлагуудыг мөрдөж ажиллахыг зөвшөөрнө.

I. Санхүүжүүлэгчнь мэдээллийн аюулгүй байдлын шаардлагыг хангуулах зорилгоор талуудынүйл ажиллагаа, хяналтын талаар мэдээлэл авч болно.

II. Талууднь Санхүүжүүлэгчийн мэдээллийн ангилал, хамгаалалт, өөрчлөлт болон хэрэгжилтийн удирдлагын талаарх мэдээллийг зайлшгүй мэдэх шаардлагатай гэж үзвэл түүний эрх бүхий ажилтанд хандаж хүсэлтээ бичгээр илгээн, Санхүүжүүлэгчийн Цахим Аюлгүй Байдлын Газраас холбогдох зөвшөөрлийг авах үүрэгтэй.

III. Гэрээний хэрэгжилтийн явцад гарсан хүндрэл, асуудлын явц, түүнд авсан арга хэмжээний талаарх хуулиар хориглоогүй тайланг Талууд харилцан бие биедээ бичгээр тайлагнана.

IV. Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа мэдээлэлд ямарваа нэг өөрчлөлт орсон бол энэ тухай өөрчлөлт оруулсан тал, нөгөө талдаа уг өөрчлөлтийг оруулснаас хойш ажлын 3 хоног дотор мэдэгдсэн байна.

V. Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л асуудлаар Санхүүжүүлэгчийг төлөөлж "Ярмаг" ХХК-ний санхүү эрхэлсэн захирал З.Нансалмаа, /Утас:99134550/, нягтлан бодогч Д.Болормаа /Утас:99105418/, зөвлөх талыг төлөөлж нийслэлийн Байгаль орчны газрын мэргэжилтэн Н.Тамир, /Утас:72720303 /, Гүйцэтгэгч талыг төлөөлж "Нүри" ХХК-ийн захирал Х.Лхагважав /Утас: 88185610/ нар хамтран ажиллана. Талууд мэдээлэл нь бүртгэгдээгүй ажилтантай мэдээлэл солилцохгүй.

**ГЭРЭЭ БИЧИГ БАЙГУУЛСАН:**

| **САНХҮҮЖҮҮЛЭГЧТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:** | **ЗӨВЛӨХ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ** | **ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ** |
|---|---|---|
| Гарын үсэг: ............................<br>Б.Нямцэрэн, "Ярмаг" ХХК-ны захирал<br><br>Гарын үсэг:............................<br>Д.Болормаа, "Ярмаг" ХХК-ны нягтлан бодогч | Гарын үсэг:..............................<br>Р.Энхтайван, Нийслэлийн Байгаль орчны газрын дарга<br><br>Гарын үсэг:..............................<br>Ч.Мөнхбаяр, Нийслэлийн байгаль орчны газрын Ойн хэлтсийн дарга<br><br>Гарын үсэг:..............................<br>Н.Тамир, Нийслэлийн Байгаль орчны газрын Ойн хэлтсийн Ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, ашиглалт хариуцсан мэргэжилтэн | Гарын үсэг:............................<br>Х.Лхагважав, "Нүри" ХХК-ны захирал<br><br>Гарын үсэг:............................<br>А.Номин, "Нүри" ХХК-ны ойн инженер |
| Хаяг: ХУД, 20-р хороо, АШҮН-ийн хашаа, Чингисийн өргөн чөлөө 145 тоот<br>Утас: 99111889, 99105418 | Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, ННЗ-ны III дугаар байр 401-420 тоот Утас: 72720303<br>Цахим шуудан: <u>Info@environment.ub.gov.mn</u> | Хаяг:Сонгинохайрхан дүүргийн 21 хороо Инчон мөрөөдлийн төгөл<br>Утас: 88185610 |

Талуудын баталгаат гарын үсэг

Санхүүжүүлэгч: .............................. Зөвлөх: .............................. Гүйцэтгэгч: ..............................

2024 оны .... дугаар сарын .... өдрийн ....... тоот дугаартай
"Өөрийн хөрөнгөөр мод тарих хамтран ажиллах гэрээ"-ний
Хавсралт 1

# ОЙЖУУЛАХ ТАЛБАЙН БАЙРШИЛ



1. 48° 7'57.84"N 106°38'48.71"E
2. 48° 7'58.71"N 106°39'10.53"E
3. 48° 7'57.96"N 106°39'10.59"E
4. 48° 7'57.16"N 106°38'49.07"E

Талуудын баталгаат гарын үсэг

Санхүүжүүлэгч: ............................ Зөвлөх: ............................ Гүйцэтгэгч: ............................

УЛААНБААТАР ХОТ
НҮРИ ХХК

Нийслэлийн байгаль орчны газар

Нүри ХХК

ТЭРБУМ МОД
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-НД ТУСГАГДСАНЫ ДАГУУ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

Танилцсан:

НБОГ-ын дарга Р.Энхтайван

Танилцсан:

НБОГ-ын Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн хэлтсийн дарга

О.Тэмүүжин

Хянасан:

НБОГ-ын ХБОБНХ-ийн Газрын хэвлийн хяналт, нөхөн сэргээлт хариуцсан мэргэжилтэн: С.Сүхцоож

Улаанбаатар хот

2024 он

- 3 настай 2.998ш шинэсийг намрын тарилтад бэлтгээд нэмэлтээр усны машин түрээслэж 5 хоногт 22 тонн усаар усалж байв.

Санхүүжилтын хүрээнд дараах үйл ажиллагааг гүйцэтгэв.

- Нүх ухаж тарилтанд бэлгэхэд
- Модны үнэ
- Холбогдох зардлыг тухай аж ахуйн нэгж байгууллагаад хариуцсан болно.

**7. Ойн зурвасын ажлыг гүйцэтгэсэн хугацаа**

Ойн зурвасын ажлыг 2024 оны 10-р сарын 05 -с 10-р сарын 26-ны хооронд хийж гүйцэтгэсэн.

Үйл ажиллагаа фото зураг

**Мод тарих газрын тэмдэглэгээ хийж байгаа зураг**



Тракотороор модны нүх ухаж байгаа зураг

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд шинэс, хайлаас мод тарьж ургуулсан газар**



**5. Ойн зурвасын ажлын бэлтгэл, зохион байгуулалт.**

Ажил эхлэхийн өмнө тухайн газарт хийх ажлаа танилцуулж, хамтарч ажилласан.

**Бэлтгэл ажлын хүрээнд**

- ➢ Ойн зурвасын ажилд хэрэглэгдэх тоног төхөөрөмж болох 2 ширхэг моторт газар ухагч болон нүх ухагч тарактор гэрээний дагуу нүх ухагчийг ажилд бэлтгэв.
- ➢ Ойн зурвасын ажилд ашиглах 1:50 000-ын сансарын болон 1:9900-ны масштабтай талбайн тойм зураг дээр ойн зурвасын ажил явуулах талбайг тэмдэглэн ажлын зураг бэлтгэсэн





- ➢ Ойн зурвасын ажилд хэрэглэх 3 настай шинэс тарьц модыг тарилтанд бэлтгэсэн.

- ➢ Ойн зурвасын ажилд ажиллах ажилчдад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар зааварчилгааг өдөр бүр өгч ажилласан.
- ➢ Ойн зурвасын ажлын мод тарьсны дараах усалгааны ажилд шаардлагатай усалгааны сав болон машин техник бэлэн болгосон.









**6. Гэрээний дагуу дараах ажлыг гүйцэтгэв.**

*Үүнд:*

- Талбайдаа мод тарих стандартын дагуу 2998 нүх ухав.
- 3 настай шинэс мод 2.998ш


- ➢ Ойн зурвасын ажилд ажиллах ажилчдад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар зааварчилгааг өдөр бүр өгч ажилласан.
- ➢ Ойн зурвасын ажлын мод тарьсны дараах усалгааны ажилд шаардлагатай усалгааны сав болон машин техник бэлэн болгосон.











**6. Гэрээний дагуу дараах ажлыг гүйцэтгэв.**

*Үүнд:*

- Талбайдаа мод тарих стандартын дагуу 2998 нүх ухав.
- 3 настай шинэс мод 2.998ш




Мод тарьхад оролцсон ААН байгууллагууд

1. Говь хувьцаат компани 1300ш нарс, хайлаас
2. Апу хувьцаат компани 800ш хайлаас
3. М Би Си Азиа Пасифик ХХК 500ш хайлаас
4. Алу Дэйри ХХК 250ш хайлаас
5. Витафит милк ХХК 403ш шинэс
6. Яармаг ХХК 600ш хайлаас
7. Элит тур ХХК 600ш хайлаас
8. Петростар ХХК 600ш хайлаас
9. Монгол тунжэн майнинг инвестмент групп ХХК 100
10. Хай Би Ойл ХК 360ш шинэс
11. Бласт ХХК 200ш-

Нийт 5713ш мод тарилаа.

Тайлан гаргасан Нүри ХХК захирал Х.Лхагважав

## 9.2. Хог хаягдлын менежмент – Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ, дагалдах бичиг

| | |
|---|---|
| "ЯАРМАГ" ХХК-ИЙН<br>ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ<br>........................................ Б.НЯМЦЭРЭН | "ТҮМЭН ЭГШИГ" ХХК-ИЙН<br>ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ<br>.............................. Г.ЧИНЗОРИГ |

**АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2024 оны 10 сарын 17-ны өдөр № ........... Улаанбаатар хот

Энэхүү аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г Монгол улсын Иргэний хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын **2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох "Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам", Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал** болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг тус тус үндэслэн болгон:

| **(ҮҮСГЭГЧ)<br>"ЯАРМАГ" ХХК** | **(ХҮЛЭЭН АВАГЧ)<br>"ТҮМЭН ЭГШИГ" ХХК** |
|---|---|
| Монгол Улс, Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 20-р хороо, Үйлдвэр /17042/,44<br>Гал унтраах 14-р ангийн урд өөрийн байранд | Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14 хороо, Намьянжугийн гудамж 44-өөрийн байр |
| Регистрийн дугаар: 2595117<br>Утас: 976-70144490, 99134550, 99040007 | Регистрийн дугаар: 5031923<br>Утас: 88990428, 91918828 |
| **Үүсгэгчийн эрх бүхий төлөөлөгч:**<br>Санүү эрхэлсэн захирал<br>З.Нансалмаа<br>Nansalmaa70@yahoo.com | **Хүлээн авагчийн эрх бүхий төлөөлөгч:**<br>Ерөнхий менежер<br>Б.Одбаяр<br>chemicalwasterisk@gmail.com |

Үүсгэгч болон Хүлээн авагч нь (тус тусад нь "Тал, хамтад нь "Талууд" гэх) энэхүү гэрээг байгуулж, доорх нөхцөлөөр харилцан тохиролцов.

**НЭГ. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА**

1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичигт заасан олон төрлийн хаягдал /цаашид "аюултай хаягдал" гэх/-ыг хүлээн авагч нь хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.

1.2. Аюултай хаягдал хүлээн авагч нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байна.

1.3. Аюултай хог хаягдлын төрөл түүнийг устгах нэгж үнийг гэрээний Хавсралт №1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ дагалдах бичгийг баталгаажуулан энэ гэрээнд хавсаргана.

1.4. Энэ гэрээ нь 2024 оны 10 сарын 20-ны өдрөөс 2025 оны 10 сарын 20-ны өдрийг хүртэл 1 жилийн хугацаатай байна.

**ХОЁР. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

2.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэхдээ дараах зүйлийг тэмдэглэсэн байна. Үүнд:

2.1.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж "Аюултай хог хаягдал" гэсэн тэмдэглэгээг тавьсан байх;

2.1.2. Аюултай хог хаягдлыг савласан сав бүрт ямар хаягдал байгаа талаарх нэр шошготой байх;



Үүсгэгч тал: ..................................... Хүлээн авагч тал: .....................................

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын
05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

# НЭХЭМЖЛЭХ № 337

Нэхэмжлэгч:
Байгууллагын нэр: **Түмэн Эгшиг ХХК**
Хаяг: **БЗД 14- р хороо Намъяанжугийн**
Утас факс: **99990428, 88990428**
Э_шуудан:**Chemicalwasterisk@gmail.com**
Банкны нэр: **Худалдаа хөгжлийн банк**
Банкны дансны дугаар: **499085408**
Регистрийн №: **5031923**

Төлөгч:
Байгууллагын нэр: **ЯАРМАГ ХХК**
Хаяг: ХУД, 20-р хороо, Үйлдвэр /17042/, Өөрийн байр 44
Гэрээний №:
Нэхэмжлэгч огноо: 2024/10/25
Төлбөр хийх хугацаа:

| № | Гүйлгээний утга | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|
| 1 | Хаягдал шуудай | 450 кг | 1,250 | 562,500 |
| 2 | Тээвэрийн зардал | | | 200,000 |
| 3 | | | | |
| 4 | | | | |
| 5 | | | | |
| 6 | | | | |
| 7 | | | | |
| 8 | | | | |
| 9 | | | | |
| 10 | | | | |
| | | | Дүн | 762,500 |
| | | | НӨАТ | 76,250 |
| | | | | |
| | | | **Нийт Дүн** | **838,750** |

**Мөнгөний дүн** *Найман зуун гучин найман мянга долоон зуун тавин төгрөг тэг тэг мөнгө*

*(Үсгээр)*

................................................................................................................ болно.

УЛААНБААТАР
(Тамга)
ТҮМЭН-ЭГШИГ ХХК
ТТГ1045 5031923

Дарга: ........................................./.................................../
Хүлээн авсан: ................................./.................................../
Нягтлан бодогч: ................................./.................................../

ТҮМЭН ЭГШИГ ХХК
САНХҮҮ
5031923
УЛААНБААТАР ХОТ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2018 оны 02 сарын 02-ны өдрийн А/21 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

## АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

№ 337

**Дагалдах бичгийн дугаар:**

*/ шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэнэ. /*

**1.Үүсгэгчийн талаарх мэдээлэл:**

Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар:

Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагын нэр: **"ЯАРМАГ" ХХК**

**2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:**

| Овог нэр | Албан тушаалтан | Гарын үсэг: | Огноо: |
|---|---|---|---|
| | ХАБЭА | | 2024 он 10 сар 25 өдөр |

**3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:**

1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар: 18-14 УБМ Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар: 0000022

**4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:**

| | Аюултай хог хаягдлын нэр | Аюулын ангилаллын зэрэглэл | Савлагааны бүлэг | Савны дугаар | Савны Төрөл | Хэмжээ | Нэгж /кг Эсвэл/ ш | Аюултай хог хаягдлын код |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хаягдал шуудай | Х | | | | 450 | кг | 150119 |
| 2 | | | | | | | | |
| 3 | | | | | | | | |
| 4 | | | | | | | | |

3. **Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:**
Тусгай Зориулалтын тээврийн хэрэгсэл

5. **Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч :**
**"Түмэн- Эгшиг" ХХК**

1. Овог нэр: Б. Одбаяр Гарын үсэг:........................... 2024 он 10 сар 25 өдөр

ТҮМЭН ЭГШИГ ХХК
ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН САВ БАГЛАА БООДОЛ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР
ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЛБА

6. **Үл зохицол:**

**8. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл:**

Аж ахуйн нэгжийн нэр: **ТҮМЭН ЭГШИГ ХХК**

Түмэн эгшиг ХХК бүртгэлийн дугаар: **-000022**

**Аюултай хог хаягдлыг хүлээн авсан:**

| Овог нэр : Түмэн эгшиг ХХК | Албан тушаал | Гарын үсэг/ тамга / | Огноо |
|---|---|---|---|
| Ч. Өсөхжаргал | Үйлдвэрийн дарга | ............................ | 2024 он 10 сар 25 өдөр |

УЛААНБААТАР
ТҮМЭН ЭГШИГ
ХХК
ТТГ1045 5031923


"TUMEN EGSHIG" LLC
9999-0428
8899-0428
www.tumenegshig.mn
tumen egshig LLC
АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДА
АРХИВ, БИЧИГ БАРИМТ УСТГАЛ


FUSO
18 93 УЕС




1893
УЕС

## 9.3. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**
**БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Улаанбаатар хот
Утас: 11-341818 И-мэйл: bohztl@gmail.com

### СОРИЛТЫН ДҮН

| | |
|---|---|
| Дугаар он/№ | : 2024/246 |
| Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг,утас | : "Яармаг"ХХК |
| Сорьц авсан хүний нэр,албан тушаал | : Д.Сувд агаарын хэсэг |
| Сорьцын тоо,төрөл | : 1, хөрсний сорьц |
| Сорьц авсан огноо | : 2024.06.10 |
| Сорьцын тодорхойлолт | : ХУД, 20-р хороо, арьс ширний үйлдвэр |
| Шинжилгээний аргын стандарт | : MNS 3310:1991 |
| Шинжилсэн огноо | : 2024.06.20 |
| Хуудасны тоо | : 1/1 |

Үр дүн

| № | Сорьц авсан цэгийн нэр | Чийг % | pH | Ялзмаг % | Аммоний азот ($NH_4$-N) мг/кг | Нитратын азот ($NO_3$-N) мг/кг | Фосфор ($P_2O_5$) мг/кг | Сульфат ($SO_4$) мг/кг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Үйлдвэрийн хашаанаас | 1.3 | 8.1 | 12.7 | 0.2 | 0.2 | 0.8 | 75.4 |

Шинжилгээ гүйцэтгэсэн: Техникч У.Болорчимэг

Хянаж баталгаажуулсан: БОШ-ний хэлтсийн дарга Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

## СОРИЛТЫН ДҮН

| | |
|---|---|
| Дугаар он/№ | : 2024/А-96 |
| Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас | : "Яармаг" ХХК |
| Сорьцын авсан хүний нэр, албан тушаал | : Д.Сувд агаарын хэсэг |
| Сорьцын тоо, төрөл | : 1 агаар, 1 дуу чимээ |
| Сорьц авсан огноо | : 2024.05.22 |
| Сорьцын тодорхойлолт | : Улаанбаатар хот ХУД 20-р хороо Арьс ширний үйлдвэр |
| Шинжилгээний аргын стандарт | : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021 MNS 5002:2000, САЗ А07-2016 |
| Шинжилсэн огноо | : 2024.05.22 |
| Хуудасны тоо | : 1/1 |

Үр дүн :

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий | Азотын давхар исэл | Нийт тоос /TSP/ | Дуу чимээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мг/м$^3$ | | | ДБА |
| 1 | Үйлдвэр орчим | V/21 | 09:40 | 0.008 | 0.019 | 0.290 | 50 |
| **Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016, Хүлцэх агууламж (20 минутын хэмжилт)** | | | | **0.450** | **0.200** | **0.500** | **60** |

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч: Э.Оюунтуяа

Хянаж баталгаажуулсан:
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга Б.Бархасрагчаа

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ
TL 08
УИТ0235

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**
**БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Улаанбаатар хот
Утас: 11-341818 И-мэйл: bohztl@gmail.com

## СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2024/246
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг,утас : "Яармаг"ХХК
Сорьц авсан хүний нэр,албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо,төрөл : 1, хөрсний сорьц
Сорьц авсан огноо : 2024.05.22
Сорьцын тодорхойлолт : ХУД, 20-р хороо, арьс ширний үйлдвэр
Шинжилгээний аргын стандарт : САЗ А01:2022
Шинжилсэн огноо : 2024.05.27
Хуудасны тоо : 1/1
Үр дүн

| № | Сорьц авсан цэгийн нэр | Кадьми (Cd) | Хар тугалга (Pb) | Мөнгөн ус (Hg) | Хром (Cr) | Цайр (Zn) | Зэс (Cu) | Стронци (Sr) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мг/кг | | | | | | |
| 1 | Үйлдвэрийн хашаанаас | 0.6 | 12 | <0.005 | <0.5 | 297 | 30 | 456 |
| **MNS 5850:2019/ ЗДХ/** | | **3** | **100** | **2** | **150** | **300** | **100** | **800** |

Шинжилгээ гүйцэтгэсэн: Ахлах шинжээч Б.Даваасүрэн

Хянаж баталгаажуулсан: БОШ-ний хэлтсийн дарга Б.Бархасрагчаа

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВӨӨС ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ TL 08 УИТ07

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

**УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР**
**УСНЫ ТӨВ ЛАБОРАТОРИ**
*WATER SUPPLY & SEWERAGE AUTHORITY*
*CENTRAL WATER LABORATORY*

*Улаанбаатар 13340; Баянзүрх дүүрэг; 4-р хороо; Б.Доржийн гудамж*
*Утас: +976 70157034; www.usug.ub.gov.mn*

MNAS Accreditation system TL 059 MNS ISO/IEC 17025

## СОРИЛТЫН ТАЙЛАН
## TEST REPORT

| | |
|---|---|
| **Сорилтын тайлангийн дугаар** */Report No/* | 24/526 |
| **Хүсэлт гаргагчийн нэр** */Client/* | Монгол Шир ХХК |
| **Сорьц авсан хүний нэр; албан тушаал** */Sampled by/* | Т.Нэмэхбаяр, сорьц авагч |
| **Холбоо барих мэдээлэл** */Contact information/* | Баттулга,89444578 |
| **Дэд лабораторийн нэр***/Sub laboratory name/* | Хими |

| | | | |
|---|---|---|---|
| **Ерөнхий шаардлага** *General requirements* | MNS 6561:2015 | **Сорьц авсан огноо** *Sampled date* | 2024/03/19 |
| **Сорьцын тодорхойлолт** *Sample description* | Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус *Industrial effluent to main sewerage system* | **Хүлээн авсан огноо** *Received date* | 2024/03/19 |
| **Сорьц авсан аргачлал** *Sampling method* | MNS ISO 5667-10:2001 | **Шинжилсэн огноо** *Analysed date* | 2024/03/19-2024/03/22 |

| **Д/д** | **Сорьцын код** *Sample ID* | **Сорьц авсан газар** *Sample location/source* | **Сорьц авсан цэг** *Sample point* | **Хэмжээ** *Sample quantity* |
|---|---|---|---|---|
| 1 | Б240342 | ХУД, Арьс шир боловсруулах үйлдвэр | цэвэрлэх байгууламж | 0.5л |

| **Д/д** | **Шинжилгээний аргачлал** *Standard method* | **Шинжилсэн үзүүлэлт** *Parameters* | **Хэмжих нэгж** *Unit* | **ЗДА** *PL* | **Б240342** |
|---|---|---|---|---|---|
| **Химийн шинжилгээний үр дүн** */Chemical result/* | | | | | |
| 1 | MNS ISO 10523:2001 | Усны орчин pH */ pH value/* | | **6-9** | 8.07 |
| 2 | MNS ISO 11923:2001 | Умбуур бодис */ Suspended solids/* | мг/л ;*mg/L* | **400** | 60 |
| 3 | MNS ISO 6060:2001 | Химийн хэрэгцээт хүчилтөрөгч */ Chemical oxygen demand; COD-Cr/* | мг/л ;*mg/L* | **800** | 708 |
| 4 | CS 11-0037:2008 | Нийт хром */ Total chromium/* | мг/л ;*mg/L* | **1** | 0.18 |

ЗДА-Зөвшөөрөгдөхдээд агуулам ж */PL-Permissible limit/*

***End of Report***

Хянасан */Verified by/*

Цэнд-Аюушийн Болормаа
Химич-чанарын менежер
*Chemical quality manager*

Баталсан */Approved by/*

Нанзадын Цэвэг-Очир
Дарга
*Head of laboratory*

Сорилтын тайлан баталгаажуулсан гарын үсэг, тамгагүй бол хүчингүй */Test report would be invalid without signatures of the person and stamp/*
Сорилтын тайланг хэсэгчлэн хуулбарлах болон өөрчлөхийг хориглоно */The test report would be invalid if altered or reproduced except in full/*

9.4 Удирдлага зохион байгууллалтын төлөвлөгөө

Сургалт зохион  байгуулсан зураг







Мэргэжлээс шалтгаалсан өвчин


АЖЛЫН БАЙР
Ажлын байрны аюулгүй байдлыг тогтмол шалгаж, аюулгүйн зөрчил илэрвэл МЭДЭЭЛЖ арилгуулах.
Ажлын байрны үзлэгийг тогтмол хий
Ажлын байранд байгаа эд зүйлсийг ангила
Шаардлагагүй хэсгийг хаях
Ажлын багаж хэрэгслээ зөв байрлуул, шаардлага хангаагүй багаж хэрэгслийг актлуулж шинээр ав
Ажлын байраа тогтмол цэвэрлэж, эмх цэгц, аюулгүйн шаардлагыг хангах
Ангил
Цэгцэл
Цэвэрлэ

# Дотоод хяналт шалгалтын тайлан



Яармаг ХХК-ийн Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа 2024

**АЖЛЫН ТАЙЛАН**

2024.12.08

Бид Дотоод Хяналтын журам болон төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг 2024 онд авч хэрэгжүүллээ.

Үүнд:

1. Үйлдвэрлэлийн технологи болон технологийн дамжлага түүнд учирч болзошгүй эрсдэлийг ажиллагсдад долоо хоног бүрийн 4 дэх өдөр танилцуулж, технологи ажиллагаанд хяналт тавьж ажилласан.
2. Ажиллагсадын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгаалалын хувцас хэрэглэлээ бүрэн өмсөж, ажил эхлэхээс өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч, аюулгүй ажиллагааны дэвтэрт гарын үсэг зурсан эсэхэд өдөр бүр хяналт тавьж ажилласан.
3. Ажиллагсадын цаг ашиглалт, сахилга батыг өдөр бүр хянаж ажилласан. Цагын бүртгэлийг 7 хоног тутам санхүүгийн албанд хүргүүлсэн.
4. Үйлдвэрийн дотоод хяналт шалгалтын талаар удирдлагын шийдвэр, төлөвлөгөөний талаарх мэдээлэлийг нийт ажиллагсадад 2024 оны 2-р сард танилцуулсан.
5. Өдөр бүр ажил эхлэхээс өмнө үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжтэй харьцах аюулгүй ажиллагааны зааварчилгааг авсан эсэх, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих зэрэг ажлуудыг бригадын ахлагч нарт даалган хянуулсан.
6. 2024 оны 4-р сараас 5-р сарын хооронд Урьдчилан цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийн холболт болон иж бүрэн цэвэрлэгээний ажлыг хийж гйүцэтгэсэн. Гүйцэтгэлд хяналт тавихад тоног төхөөрөмжийн засварчид буруу холбох, хэмжээг зөв авахгүй байх зэрэг алдаа дутагдал гарган засварын зардлыг нэмэгдүүлэх үндсэн шалтгаан болсон.
7. Урьдчилан цэвэрлэх байгууламжийн ажиллагааг сар бүр хянахад лаг усгүйжүүлэх төхөөрөмжийн ажиллагаа байнга доголдож бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологийн явц удаашрах болсон байсанг 4-р сард 3 хоног зогсоож бүрэн гүйцэт засвар хийсэн. 3, 4-р сард УСУГ-ын нарийвчилсан хяналт шалгалт хийсэн. 3-р сард бохир усны шинжилгээг УСУГ-аас авсан.
8. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, суваг шуудууны цэвэрлэгээг тухайн өдөр бүр ажил дууссаны дараа хийж гүйцэтгэсэн эсэхэд хяналт тавьж ажилласан. Зарим өдөр суваг шуудууны цэвэрлэгээнээс бусад засварын ажил ялангуяа махлах машины засвар,



Яармаг ХХК-ийн Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа 2024

хяналтыг ажлын дундуур хийсэн гээд засварчид эрт явсан дутагдал гарсанг势 сануулах арга хэмжээ авагдсан.

9. Үйлдвэрлэлд хэрэглэгдэж байгаа химийн бодисын ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд сар бүр хяналт тавьж ажилласан учир учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэн ажиллаа.
10. Химийн бодистой харьцдаг ажиллагсад болон нийт ажиллсагсаддаа химийн бодистой хэрхэн харьцах талаар сургалт, танилцуулгыг хийж, хамгаалах хэрэгсэл хэрхэн ашиглах талаар, хувийн хамгаалалтаа сайжруулах тал дээр анхаарч аюулгүй ажиллагааны дүрмээ баримтлан ажиллаа.
11. Химийн бодисыг үйлдвэрлэлийн хэрэгцээнд хүлээн авахдаа зөвхөн тухайн өдрийн хэрэглээний дагуу хүлээн авч, бүтээгдэхүүн тус бүрээр агуулахад хадгалж байна.
12. 2023 онд химийн материалын агуулахын арчлалт тордолтыг хийсэн тул энэ жил улирлын ажил дуусахад их цэвэрлэгээ хийсэн.
13. Ажиллагсдын хувцас солих өрөө болон угаалгын өрөөг засварласан. Угаалгын машин эвдэрсэнг шинээр авч тавьсан. Мөн өдөр бүр нойтон цехийн ажилчид усанд ордог тул цэвэрлэгээг хийх 1 ажилтанг гаргасан. Энхзаяа илүү цагаар ажлын дараа энэ ажлыг хийхээр тохиролцсон. Гаднаас хүн аваагүй. Өдөр бүр цэвэрлэгээний цалин -50000 төгрөг олгосон. Нэг цэвэрлэгч дангаараа хийхэд хэцүү байна гэж гомдол гаргасан тул 3-4р саруудад Энхзаяа 1 цаг зөвхөн усанд ордог 4 дүшийг цэвэрлэж байсан.
14. Үйлдвэрийн ажилчидад тавьж олгосон ажлын нормын хувцас хэрэглэл, хөдөлмөр хамгаалалын зардалд 2024 онд төлөвлөсөн хэмжээгээр олгов. Үйлдвэрлэлд өдөрт хамгийн олондоо 30 хүн ажилласан.
   - Маск, даавуун бээлий(1 хоног тутамд) – Давуун бээлий 1800 ш, маск 150 ширхэг,
   - Бээлий резинэн(өдөр бүр) цоорсон тохиолдолд нэмж олгодог. Нийт 2114 ширхэг,
   - Ханцуйвч, хормогч (7 хоногт нэг удаа) – хормогчийг өмнөх жил оёуулсан газар бүсийг муу хийснээс олныг олгож байсанг, энэ жил анхааран бүсийг сайн материалаар хийлгүүлсэн тул харьцангуй бат бөх байсан. Нийт ханцуйвч 186 ш, хормогч 180 ш
   - Усны гутал, Ажлын хувцас (Улиралд нэг удаа) нормын дагуу тавьж олгосон. Усны гутал 30 ширхэг урт түрийтэй, 60 ширхэг богино түрийтэй гутал тус тус зарцуулагдсан байна.
15. Үйлдвэрийн байранд болон үйлдвэрийн гадна талбайд Ариутгал халдваргүйжүүлэлтийн компанитай гэрээтэй тогтмол хийлгэж ажилласан.



Яармаг ХХК-ийн Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа 2024

Үйлдвэрийн байрны цонхыг онгойлгож  агааржуулалт, агаарын сэлгээг цаг тутамд хийсэн. Агааржуулалтын хоолойнд байнга шалгаж байлаа. Агаарын чийгшилтээс болж хөлддөг явдлыг арилгасан.

16. Энэ жил галын аюулгүй байдлын дүгнэлтийн хугацаа дууссан тул ахин авахаар хүсэлт гарган холбогдох газарт хандан, галын аюулгүй байдлын стандартын хяналт шалгалтыг хийлгүүлсэн. Галын хор, хүрз, хувин, галын аюулгүй байдлын самбар зэргийг шинэчлэсэн.
17. Үйлдвэрлэлийн процесс бүрт хийх хяналтыг 7 хоногт бүтээгдэхүүний нэр төрөл бүрээр хийсэн. Өмнөх онд бэлэн болсон нойтон хромлосон арьсыг дахин тоолж ялган цэгцэлсэн. Ажлын гутал хийхэд нимгэдсэн арьсыг ялган тэмдэгжүүлж дотуур ул хийх зориулалтаар хадгалж байна. Өмнөх жилийн хромлосон арьснаас нядалгааны үеийн гэмтэлтэй арьс нийт арьсны 60 хувийг давсан тул хромон гутлын арьс хийх боломжгүй болсон, зөвхөн дотуур уланд зориулан хадгалсан. Иймээс үлдэгдэл маш их байгаа. Үйлдвэрлэлийн процесст алдаа дутагдал гараагүй 2023 онд Италийн захиалгаар нимгэн хуваасан арьсны нийт үлдэгдэл одоо 4 чингэлэг үлдсэн.  Монголын зах зээлд борлуулах боломжгүй.
18. Улны шир болон дотуур ул хийхэд зориулсан ургамлын идээлгийн нөөц дуусаж байгаа тул захиалга яаралтай өгөх шаардлагатай. Санхүүгийн алба одоо хүртэл мөнгөгүй гээд захиалгыг баталгаажуулахгүй байна. Энэ тал дээр удирдлагууд сайн анхаарах хэрэгтэй. Цаг хугацаанд материалын татан авалт хийхгүй бол үйлдвэрлэл зогсоно. Энэ 2 бүтээгдэхүүн бол манай компанийн дотоодын зах зээл дээрх хамгийн чухал бүтээгдэхүүн хичнээн монголын зах зээл бага ч бид улсдаа улны шир, дотуур улыг үйлдвэрлэж чаддаг гэдгийн баталгаа билээ.
19. Технологийн картыг 7 хоног бүр шалгаж байсан, нэмэлт идээлгийн хэсгийг хариуцсан Тэмүүжин технологичийн карт зарим өдөр дутуу бөглөлттэй байсанг сануулж, 7 хоногийн турш өдөр бүр хяналт тавьснаар дахин алдаа дутагдал гаргаагүй. Дутуу байсан 3 өдрийн карт туршилтын барбанд бакаль гутлын технологийг шинэчлэхээр хийгдсэн туршилтынх байсан. Технологич гүйцээн бөглөж өгсөн. Энэ туршилт материалын хэмжээг бууруулахаар хийгдсэн туршилт. Туршилтын дүнгээр технологийг өөрчлөөгүй тул зөвхөн бүртгэлд ашигласан материалыг тооцоход хэрэглэгдсэн.
20. Дотоод хяналт шалгалтын талаарх төлөвлөгөөний хэрэгжилтийг явцыг улирал бүр, хяналт шалгалтын мөрөөр хийсэн ажлын үр дүнгийн тайланг байгууллагын удирдлагад тухай бүр танилцуулж ажиллалаа.

Тайлан бичсэн: Н.Шаравжамц

## Өдөр тутмын ХАБЗ болон хамгаалах хувцас хэрэглэл олгосонг баталгаажуулалт хийгдсэн байдал







## Хөрсний ариутгал халдваргүйжүүлэлт хийгдсэн байдал







Монгол Улсын Шадар сайдын 2023 оны
11 дүгээр сарын 10-ны өдрийн 75 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

# ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар 0010279

Иргэн, хуулийн этгээдийн нэр: **"ЯАРМАГ" ХХК**

Хаяг: **ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРОО, АШҮН-ИЙН ХАШААНД ӨӨРИЙН БАЙР**

Эрхлэх үйл ажиллагааны чиглэл:

**"АРЬС ШИР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР"**

Барилга байгууламж, газрын тосны бүтээгдэхүүн тээвэрлэх авто тээврийн хэрэгслийг ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.
/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 19 дүгээр зүйлийн 19.2, 23 дугаар зүйлийн 23.3/
/Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4/

Хяналт шалгалт хийсэн **2024** он **12** сар **10** өдөр
Олгосон: он сар өдөр
Хүчинтэй хугацаа: **2025** он **12** сар **10** өдөр хүртэл

Баталгаажуулсан:

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН** аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
дарга **ХУРАНДАА** цолтой **Д.БАТ-ЭРДЭНЭ**

Дүгнэлт олгосон:

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН** аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
Гал түймрийн улсын хяналтын байцаагч **ХОШУУЧ** цолтой **Ц.БАРСХҮҮ**

/тэмдэг дарна/

**“ЯАРМАГ ” ХХК**

Монгол улс, Улаанбаатар хот ,
Хан-Уул дүүрэг 20-р хороо, Үйлдвэр-17042/44
Гал унтраах 14-р ангийн урд өөрийн байранд
Утас: 99040007, 99134550

2024.12.19 № 043
Танай ___________-ны № ______________

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүргүүлэх тухай

Манай компани ХУД-ийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлан 32 жилийн турш арьс шир боловсруулах үйл ажиллагаа эрхэлж байна.

Манай компани 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө БОАЖЯ-аар батлуулсан. “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 14-р зүйлийн 14.1.2 дэх хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 1-р сарын 6-ны өдрийн А/05 дугаар тушаалаар батлагдсан журам болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах үүргийн дагуу Байгаль орчны менежментийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүргүүлж байгааг хүлээн авна уу.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.НЯМЦЭРЭН

2020 онд байгуулсан ойжуулалтын гэрээ 2024 онд хүлээлгэн өгөх ёстой байсан. Ногоо хишигтэн ТББ-аар Богины аманд 100 ширхэг шинэс модны суулгац суулгасан байдал, 2021 онд тухайн аманд мод тариулсан компаниудтай хамтран хамгаалалтын хашаа бариулсан зургуудаас

## ОЙЖУУЛАЛТЫН ГЭРЭЭ

№ 2020/04.

2020 оны 5-р сарын 4-ны өдөр Улаанбаатар хот

Энэхүү **ОЙЖУУЛАЛТЫН ГЭРЭЭ** (цаашид "Гэрээ" гэх)-г Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйл, Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, бусад холбогдох дүрэм журмыг удирдлага болгон,

нэг талаас: **"Яармаг" ХХК** (цаашид "А тал" тал гэх)-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал албан тушаалтай Б.Нямцэрэн,

нөгөө талаас: Монгол улс, Улаанбаатар хот, Хан Уул дүүргийн 15 хороо, Нархан хотхон, 59-21 тоотод байрлах, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, регистрийн дугаар 8273731 бүхий **"Ногоон Хишигтэн ТББ"** (цаашид "Б тал" тал гэх)-ийг төлөөлж ТУЗ-ын дарга албан тушаалтай Э.Цэцгүн, хамтад нь ("Талууд" гэнэ ) гэх нар харилцан тохиролцож доорх нөхцөлөөр гэрээг байгуулав.

### НЭГ. УДИРТГАЛ ЗААЛТ

1.1. А тал нь дараах нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр энэхүү гэрээг байгуулсан болно. Үүнд:

1.1.1. Б тал нь энэхүү гэрээг хэрэгжүүлэх ойжуулалт, байгаль орчны нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага;

1.1.2. Б тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх туршлага, ур чадвар бүхий мэргэжлийн боловсон хүчинтэй;

1.1.3. Б тал нь Гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлд батлагаа өгч, аливаа гарч болох эрсдэлийг хариуцах чадвартай.

1.2. **Гэрээний зорилго:** Энэхүү гэрээгээр Б тал нь энэ гэрээний 2-т заасан ажлыг гүйцэтгэх, А тал нь гэрээнд тохиролцсон төлбөрийг төлөхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

### ХОЁР. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

2.1. **Гэрээт ажил:** Гэрээний хугацаанд Б тал нь Богд Хан уулын хамгаалалтын захиргаанаас заагдсан **0,5** га талбайд технологийн суулгац суулгах, бордох, нөхө тарилт хийх ажил (цаашид "Гэрээт ажил" гэнэ)-г холбогдох журам, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

2.2. **Суулгац бэлдэх, тарьж ургуулах, арчлан хамгаалах ажил:** Б тал нь шинэс модны суулгацыг технологийн дагуу үрслүүлэн бойжуулж тарилтанд бэлдэнэ.

8.3. Хэрэв Талуудын аль нэг нь нэг талынхаа нууцыг Гэрээний 9.2-т заасныг зөрчиж задруулсан бол учирсан хохирлыг хариуцан арилгана.

## ЕС. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

9.1. Гэрээний явцад талуудын хооронд үүссэн бүх маргаан, зөрчилдөнийг талууд зөвшилцөж шийдвэрлэнэ.

9.2. Хэрэв санал зөрчилдөөнийг зөвшилцөн шийдвэрлэж чадахгүй бол хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## АРАВ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ БОЛОН ДУУСГАВАР БОЛГОХ

**10.** Талууд гэрээний үүргийг бүрэн гүйцэтгэсэн бөгөөд гэрээний зорилгыг бүрэн биелүүлсэн гэж үзсэн тохиолдолд энэхүү гэрээ дуусгавар болно.

**11.** Гэрээ дуусгавар болсон тохиолдолд Талууд Гэрээ дүгнэх акт үйлдэж баталгаажуулна.

## АРВАН НЭГ. БУСАД ЗААЛТ

11.1. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хүсвэл, энэ тухай саналаа нөгөө талдаа мэдэгдэж, харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр оруулна.

11.2. Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж гарын үсэг зурж, тамга дарснаар хүчинтэй болох ба хууль зүйн хувьд хувь тус бүр адил хүчинтэй байна.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

"А"талыг төлөөлж:
Гүйцэтгэх захирал ................................../Б.Нямцэрэн
Хаяг:
ХУД 2- хороо Үйлдвэр-17042/44, Улаанбаатар хот, Монгол Улс
Утас: 99134550, 99040007

"Б" талыг төлөөлж:
ТУЗ-ын дарга ................................................../ Э.ЦЭЦГҮН
Хаяг:
..........................................................................................................
..........................................................................................................
............

УЛААНБААТАР ХОТ
НОГООН ХИШИГТЭН НҮТББ
1118260663 ☎ 8273731












86 30 УБУ







